ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон, П.Гэндэнгийн гудамж,
5 дугаар баг, Арвайхээр сум, Өвөрхангай аймаг, 62173,
Утас/Факс: (976) 7032 3253,
Цахим шуудан: uvurkhangai@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.04.17 № 315
танай ________ -ны № ________ -т

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
АРДЧИЛСАН НАМЫН
ХОРООНД

Дүгнэлт хүргүүлэх тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх заалт, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5 дахь хэсгийг үндэслэн Өвөрхангай аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгуульд оролцох аймгийн Ардчилсан намын хорооны Сонгуулийн мөрийн хөтөлбөр, хандивын тайланд хийсэн аудитын дүгнэлтийг хүргүүлж байна.

Хавсралт 46 хуудастай.

ДАРГА,ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР О.БАТЖАРГАЛ

6225020506

D:\Auditiin gazar\baiguullagiin dotood barimt\A4

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
Нутгийн удирдлагын ордон, П.Гэндэнгийн гудамж,
5 дугаар баг, Арвайхээр сум, Өвөрхангай аймаг, 62173,
Утас/Факс: (976) 7032 3253,
Цахим шуудан: uvurkhangai@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.04.17 № 205
танай ____________-ны №____________-т

АРДЧИЛСАН НАМЫН ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ХОРООНД

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд заасан шаардлагад нийцсэн талаарх дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3, 5.4-т заасны дагуу Төрийн аудитын байгууллага Өвөрхангай аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгуульд оролцох Ардчилсан намын Өвөрхангай аймгийн хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Өвөрхангай аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгуульд оролцох Ардчилсан намын Өвөрхангай аймгийн хороо нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь Өвөрхангай аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгуульд оролцох Ардчилсан намын Өвөрхангай аймгийн хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай

6225020483

хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

**Дүгнэлт**

Ардчилсан намын Өвөрхангай аймгийн хорооны Өвөрхангай аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Ардчилсан намын Өвөрхангай аймгийн хорооны мөрийн хөтөлбөр (..40..хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Өвөрхангай аймгийн Сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР О.БАТЖАРГАЛ

D:\Auditiin gazar\baiguullagiin dotood barimt\A4

## ҮЗЭЛ БАРИМТЛАЛ, ЗАРЧИМ

### АЛСЫН ХАРАА
### ЗОРИЛТ

Нэг.

**ХҮНЭЭ ДЭЭДЭЛСЭН ХҮНИЙ ХӨГЖЛИЙН "БҮТЭЭЛЧ ӨВӨРХАНГАЙ"**

(Боловсрол, эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал, соёл урлаг, спорт)

Хоёр.

**ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖИЛ**

(Аж үйлдвэр, хөдөө аж ахуй, уул уурхай, аялал жуулчлал)

Гурав.

**ДЭД БҮТЭЦ**

(Инженерийн шугам сүлжээ, зам барилга, эрчим хүч, мэдээлэл харилцаа)

Дөрөв.

**САЙН ЗАСАГЛАЛ**

(Иргэндээ үйлчилдэг засаглал)

Тав.

**"АЮУЛГҮЙ, НОГООН ӨВӨРХАНГАЙ"**

(Хүрээлэн буй орчин, экосистемийн тэнцвэртэй байдал, байгаль орчны тогтвортой хөгжил)

# ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН АРДЧИЛСАН НАМЫН 2024 ОНЫ АЙМАГ, СУМЫН ИТХ-ЫН СОНГУУЛИЙН "БҮТЭЭЛЧ ӨВӨРХАНГАЙ" МӨРИЙН ХӨТӨЛБӨР

- ✓ ОРОЛЦОО МАНЛАЙЛАЛ ХАМТЫН ХҮЧ
- ✓ БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ НӨЛӨӨЛӨЛ
- ✓ ШИЙДВЭР, ХЭРЭГЖИЛТ ҮР ДҮН




Арвайхээр сум, Өвөрхангай аймаг,
Монгол улс, 2024 он

АРДЧИЛСАН НАМ
ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН НАМЫН ХОРОО
9023041590
8488915 ХТQ7665

## ҮЗЭЛ БАРИМТЛАЛ, ЗАРЧИМ

1. Өвөрхангай аймгийн Ардчилсан намын 2025-2029 онд хэрэгжүүлэх хөгжлийн хөтөлбөрийн баримтлах бодлого нь "Монгол Улсын Үндсэн Хууль"-д заасанчлан эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэх зорилгыг эрхэмлэн дээдэлж, ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн хэмээснийг ёсчлон биелүүлэхэд оршино.




2. 2015 онд НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 70 дугаар чуулган АНУ-ын Нью-Йорк хотноо салбар хуралдаанаар баталсан "Тогтвортой хөгжил-2030" хөтөлбөрийн зорилтуудыг дэмжинэ. "Тогтвортой хөгжлийн 2030 хөтөлбөр" нь тунхаглал, тогтвортой хөгжийн 17 зорилго, 169 зорилтоос бүрдсэн ба тэдгээрийг хэрэгжүүлэхэд дэлхийн орнууд хэрхэн хамтран ажиллах тухай тусгасан байна.

3. Монгол Улсын Их хурлын 2020 оны 5 дугаар сарын 13-ний өдрийн 52 дугаар тогтоолоор баталсан "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод заасан "Чанартай амьдралын баталгаа бүхий нийгмийн хамгааллалтай, аз жаргалтай амьдралын ээлтэй орчинд, гэр бүлийн амьдралын баталгаа, улс орны хөгжлийн суурь болсон чанартай боловсролыг хүн бүр эзэмших боломжийг




4. Үндэсний эв нэгдэл, шударга ёсыг дээдлэх, ялгаварлан гадуурхалгүйгээр аймгийн хөгжлийн талаар бодлого, шийдвэр боловсруулах, хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт шинжилгээ үнэлгээ хийхэд иргэдийн эрх ашгийг хамгаалах чиг үүрэг бүхий улс төр, иргэний нийгмийн байгууллагын төлөөллийн оролцоог ханган ажиллах төрийн үзэл баримтлалыг ... ажиллана;

АРДЧИЛСАН НАМ
ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН НАМЫН ХОРОО
9023041590
6488916 ХТ07685

5.Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, "Хот, хөдөөгийн сэргэлтийн бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар авах арга хэмжээний тухай" Засгийн газрын тогтоол зэрэг төр, захиргааны байгууллагуудын бодлого шийдвэрүүд, "Хүн амын нутагшилт, суурьшлын хөтөлбөр, аймгийн хөгжлийн чиг баримжаа" зэрэг судалгаагаар дэвшүүлсэн хөгжлийн чиглэлүүдийг зарчмаа болгон баримтална.




## ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ХӨГЖЛИЙН АЛСЫН ХАРАА

Унаган байгаль экологийн тэнцвэрийг хадгалж, байгаль орчныхоо онцлогт тохирсон хөдөө аж ахуй, үйлдвэрлэл үйлчилгээ, аялал жуулчлал хөгжсөн, тээвэр логистикийн оновчтой бүтэц бүхий ногоон хөгжлийг эрхэмлэсэн, өөрийгөө тэтгэдэг эдийн засагтай, чинээлэг дундаж давхарга давамгайлсан, иргэддээ сэтгэл хангалуун ажиллаж амьдрах таатай боломжийг бүрдүүлсэн ухаалаг засаглалтай аймаг байна.

## ҮНДСЭН ЗОРИЛТ

Хот, хөдөөгийн тэнцвэрт хөгжлийг хангах зорилтын хүрээнд орон нутгийг хөгжүүлэх, нийслэлээс орон нутагт шилжин суурьших иргэдийн ажиллаж, амьдрах нөхцөл боломжийг нэмэгдүүлэх, орон нутагт үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгж, байгууллагуудыг дэмжих, хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг удирдлага, зохион байгуулалтаар хангаж үр дүнд хүрч ажиллахад үндсэн зорилт оршино.

Тус хөтөлбөрийн үндсэн агуулга нь Аймгийн хэмжээнд тулгамдаж буй асуудлууд, тэдгээрийн шийдлийг иргэдийн өөрсдийнх нь оролцоотойгоор бодлогын түвшний, нотолгоонд суурилсан арга зүй, төлөвлөгөө боловсруулж, нөлөөллийн хөтөлбөрүүдийг дэс дараатайгаар амжилттай хэрэгжүүлэх явдал билээ. Түүнчлэн нийгмийн олон бүлгүүдийн бодит оролцоог нэмэгдүүлэх, манлайллыг идэвхжүүлж, нийгэмд зөрөг, зөв хандлагыг бий болгох, шийдвэр гаргах түвшинд хувь нэмрээ оруулж чадахуйц чадварыг олгоход чухалчлан багтаасан болно.



*"Чанартай амьдралын баталгаа бүхий нийгмийн хамгаалалттай, аз жаргалтай амьдралын ээлтэй орчинд, гэр бүлийн амьдралын баталгаа, улс орны хөгжлийн суурь болсон чанартай боловсролыг хүн бүр эзэмших боломжийг бүрдүүлэн, нийгмийн идэвхтэй, эрүүл монгол хүнийг хөгжүүлнэ."*

*"Алсын хараа-2050" Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого|Хүний хөгжил*

АРДЧИЛСАН НАМ
ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН НАМЫН ХОРОО
9023041590
8488916 ХТО7668

## Нэг. ХҮНИЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙН ХАМГААЛАЛ

### 1.1. БОЛОВСРОЛ

Хүн амын тогтвортой өсөлтийг хангаж, хүн бүрийг эрдэм боловсрол төгс, хөдөлмөрч, бүтээлч сэтгэлгээтэй, эрүүл амьдралын хэв маягийг хэвшил болгон, Өвөрхангай нутгийнхаа байгаль, түүх соёл, уламжлалаараа бахархсан эв тэгш хүмүүжилтэй, ардчиллын үнэт зүйлсийг эрхэмлэсэн, хувийн өмчөөт эдийн засгийг дэмжсэн хөгжлийн бодлого хэрэгжүүлнэ.

1.1.1 Монгол хүн үндэсний өв соёлоороо бахархах, өвлүүлэх, үндэсний хэл, бичигт суралцахыг дэмжих замаар үндэсний эв нэгдлийг сахин хамгаална. Гэр бүлийн боловсрол олгох "Монгол гэр бүл" боловсролын хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлнэ

1.1.2 Хүүхдийн хүмүүжил, төлөвшлийн асуудалд онцгой анхаарч, цэцэрлэгийн өмнөх насны хүүхдийг хүмүүжүүлэх бодлогыг шинэчлэн, хүүхдийг гэр бүлийнхээ орчинд эцэг, эхтэйгээ хамт хүмүүжин төлөвших хөтөлбөр, заах аргыг хөгжүүлнэ.

1.1.3 Хүүхэд гэр бүл, цэцэрлэг, сургуулийн орчинд эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх орчны эрүүл мэндийг сайжруулах бодлогыг нийгмийн эрүүл мэндийн үндсэн чиглэл болгоно.

1.1.4 Цэцэрлэг, сургуулийн нэг ангийн хүүхдийн тоог стандартын шаардлагад нийцүүлэн мөрдөнө.

1.1.5 Малчин өрхийн бага ангийн хүүхдийг "Баг"-ийн бага сургууль болон гэрээр хослон сургах "гэрт ойр" тогтолцоо нэвтрүүлнэ.

1.1.6 Хүүхэд харах үйлчилгээг хөгжүүлэн, цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.

1.1.7 Хүүхэд сургуульдаа аюулгүй ирж, буцах нөхцөлийг бүрдүүлж сургуулийн автобусаар үйлчилнэ.

1.1.8 Цахим орчинтой харилцах, цахим орчинд ажиллах чадвар эзэмшүүлэх боловсролыг дэмжинэ

1.1.9 Дотуур байрны орчин, нөхцөлийг сайжруулна.

1.1.10 Хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлж, насны онцлогт тохирсон нийгмийн үйл ажиллагаанд оролцох, үзэл бодлоо илэрхийлэх боломжийг дэмжинэ.

1.1.11 Хүүхдэд тулгарч буй дээрэлхэх, үе тэнгийнхний дарамт, шахалт болон эрүүл мэнд, сэтгэцийн бусад сорилт, бэрхшээлтэй холбоотой асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэсэн төсөл хэрэгжүүлнэ.

1.1.12 Хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын "цөм" хөтөлбөрийг үргэлжлүүлж, төр, орон нутаг, иргэний нийгмийн байгууллага, гэр бүлийн оролцоог өргөжүүлнэ.

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН НАМЫН ХОРОО

1.1.13 Хүүхдийг цахим дарамт, мөлжлөг, зохисгүй контент зэрэг цахим гэмт хэрэг, аюулаас хамгаалах үйл ажиллагаанд оролцогч талуудын уялдаа холбоог сайжруулна.

1.1.14 Хүүхэд оюутан, залуучууд өсвөр үеийнхнийг нийгмийн сөрөг нөлөө, гэмт хэрэгт өртөх, мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэхээс сэргийлэх аюулгүй байдлыг хангахад онцгой анхаарна

1.1.15 Олон улсад магадлан итгэмжлэгдсэн, дэлхийн шилдэг их, дээд сургуульд суралцах оюутны идэвх, санаачилгыг дэмжиж ажиллана.

1.1.16 Залуучуудын хөгжлийн төв байгуулж, чөлөөт цагаа өнгөрөөх, хамтдаа хөгжих, суралцах орчныг бүрдүүлнэ.

1.1.17 Ахмадын сургалт-амралтын төвийг байгуулж, дахин ур чадваржуулах бүхий л санал санаачилгыг дэмжинэ.

1.1.18 Цахим шилжилтийг бүрэн хэрэгжүүлж, боловсролын сургалтын байгууллагууд сургалтыг танхим ба цахим хосолсон хэлбэрээр зохион байгуулах боломжийг бүрдүүлнэ.

1.1.19 Сурагчдын сонирхол, чадварыг дэмжин хөгжүүлэх чиглэлээр хичээлээс гадуурх сургалт, сонгон, секц, клубуудын үйл ажиллагааг өргөтгөнө.

1.1.20 Багш нарын цахим боловсролын ур чадварыг сайжруулах хөтөлбөрийг дэмжиж ажиллан.

1.1.21 Багшийн мэргэжлийн ур чадвар, нэр хүнд, ёс зүйд тавигдах шалгуурыг боловсронгуй болгож, хариуцлагын тогтолцоог сайжруулна.

## 1.2. ЭРҮҮЛ МЭНД

1.2.1 Өрх, суманд үзүүлэх 0-5 насны хүүхдийн тусламж, үйлчилгээг чанаржуулах, хүртээмжийг сайжруулах, хөхөөр хооллолтыг дэмжих "Эрүүл, чийрэг хүүхэд" хөтөлбөр хэрэгжүүлнэ.

1.2.2 Бүх нийтийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх цогц хөтөлбөр хэрэгжүүлж, эрүүл аж төрөх дадлыг хэвшүүлнэ.

1.2.3 Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх шинэ хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлнэ.

1.2.4 Иргэдийн халдварт болон халдварт бус өвчлөл, нас баралт болон эх, нярайн эндэгдлийг бууруулж, урьдчилсан сэргийлэх үзлэг оношилгоо, эрт илрүүлгийн хамрагдалтыг нэмэгдүүлнэ.

1.2.5 Эмч эмнэлгийн ажилчдын ур чадварыг дээшлүүлэх, эмчилгээ үйлчилгээний чанарт хяналт тавихад иргэний хяналт оролцоог нэмэгдүүлнэ.

АРДЧИЛСАН НАМ
ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН НАМЫН ХОРОО

1.2.6 Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн гүйцэтгэлийн санхүүжилтийг сайжруулж, өдрийн болон гэрийн эмчилгээ, асаргаа сувилгаа, сэргээн засах, хөнгөвчлөх үйлчилгээний төрлүүдийг хөгжүүлнэ.

1.2.7 Хүн амын хүнсний чанар, шим тэжээлийг сайжруулж, тэнцвэртэй, эрүүл хооллолтын зохистой дадлыг хэвшүүлнэ.

1.2.8 Хорт хавдраас сэргийлэх зорилтын хүрээнд хавдрын оношилгоо, эмчилгээний хөнгөвчлөх үйлчилгээ үзүүлэх төвийг өргөжүүлнэ.

1.2.9 Нийгмийн эрүүл мэндийн тусламжийн тухай хуулийг биелүүлж, эрүүл мэндээ хамгаалсан иргэдийг урамшуулах тогтолцоог бий хэрэгжүүлнэ.

1.2.10 Эрүүл мэндийн салбарын ажилтнуудын мэргэжил, боловсролыг тасралтгүй дээшлүүлэх, резидент сургалтад хамруулах, ур чадварыг үнэлэх, цалин хангамжийг нэмэгдүүлэх, салбарын удирдлагын менежментийг сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

1.2.11 Эрүүл мэндийн байгууллагуудыг нэн шаардлагатай орчин үеийн техник, тоног төхөөрөмжөөр /олон зүсэлтэт КТГ, MRI, лабораторийн тоног төхөөрөмж/ эн тэргүүнд хангахын зэрэгцээ өвчтөний оношилгооны баталгаажуулалтыг аймгийн эмнэлэгтээ бүрэн хангаж ажилладаг болно.

1.2.12 Эмийн сангуудын менежментийг боловсронгуй болгож, чөлөөт өрсөлдөөнийг дэмжин, эм, эмнэлгийн хэрэгслийн [illegible] хангамж нийлүүлэлтийг сайжруулна.

1.2.13 Нарийн мэргэжлийн эмч, эмнэлгийн ажилтнуудыг анагаахын өндөр хөгжилтэй орнуудад мэргэжил дээшлүүлж, сургана.

1.2.14 Эмийн бус, нөхөн сэргээх эмчилгээний цар хүрээг өргөжүүлнэ.

1.2.15 Явуулын нарийн иж бүрэн үйлчилгээг нэвтрүүлнэ.

1.2.16 Монголын уламжлалт анагаах ухааныг орчин үеийн анагаах ухаантай хослуулан хөгжүүлнэ

1.2.17 Яаралтай түргэн тусламжийн сүлжээг боловсронгуй болгоно

1.2.18 Хиймэл оюун ухаан, алсын зайн болон мобайл технологи, цахим үйлчилгээг хөгжүүлнэ

1.2.19 Сэргээн засах, сувилахуй, хөнгөвчлөх тусламжийг хөгжүүлнэ

1.2.20 Эмийн чанар, аюулгүй байдлын цахим тогтолцоог бүрдүүлж, клиникийн эм зүйг хөгжүүлнэ

1.2.21 Орчин үеийн дэвшилтэт оношилгоо, эмчилгээний технологийг нутагшуулна

1.2.22 Эрүүл мэндийн байгууллагын барилга байгууламж дэд бүтцийг сайжруулна

## 1.3. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

1.3.1 Хүүхэд харах үйлчилгээг өргөжүүлж, эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.

АРДЧИЛСАН НАМ
ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН НАМЫН ХОРОО
9023041590
8488916 ХТО7666

1.3.2 Ажил, хөдөлмөр эрхлэх, санхүү, бизнесээ өргөжүүлэх, амьдрах орчноо хамтдаа сайжруулах мэдлэг, ур чадварын сургалт, зөвлөмжөөр хангагдах боломжийг орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан хэрэгжүүлнэ.

1.3.3 Зохион байгуулалттай хөдөлмөр зуучийн үйлчилгээг дэмжиж, цагийн ажлын тогтолцоог урамшуулна.

1.3.4 Орон нутагт ажиллаж буй залуучуудыг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлнэ.

1.3.5 Төрийн албанаас эрт тэтгэвэрт гарч буй иргэд жижиг дунд, бичил бизнесийн салбарт ажиллах, баялаг бүтээх боломжийг бүрдүүлнэ.

1.3.6 Хөгжлийн бэрхшээлтэй хүн тогтмол орлого олох хөтөлбөр хэрэгжүүлнэ.

1.3.7 Гадаадад суралцаж, ажиллаж байгаа болон эх орондоо эргэн ирж байгаа залуучуудад зориулсан хөтөлбөр хэрэгжүүлнэ.

1.3.8 Гадаадад ажиллаж байгаа иргэдийн мэргэшсэн байдлыг харгалзан өөрийн туршлага, шинэ мэдлэг шингэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг орон нутагтаа нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

1.3.9 Инженерийн чиглэлээр мэргэжилтэн бэлтгэх хөтөлбөрийг үргэлжлүүлнэ.

1.3.10 Иргэд ажиллангаа суралцах, суралцангаа хөдөлмөр эрхлэх хөтөлбөр хэрэгжүүлж, өөрөө өөртөө ажлын байр бий болгох, бизнес эрхлэх боломжийг бүрдүүлнэ.

1.3.11 Ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих замаар алслагдсан бүс нутагт дутагдалтай мэргэжилтнүүдийг бүрдүүлэх "Ахмад мэргэжилтний алба" ажиллуулах санаачилга, хөдөлгөөн өрнүүлнэ.

1.3.12 Бизнес, хөдөлмөр эрхлэлтийг бүх талаар дэмжиж, дундаж давхаргын эгнээг тэлнэ.

1.3.13 Цалин хөлсийг ажлын байранд өнгөрүүлсэн хугацаагаар бус ажлын үр дүнгээр тооцдог аргачлалыг нэвтрүүлнэ.

1.3.14 Цагаар ажиллах, гэрээр ажиллах, зайнаас ажиллуулах, сүлжээний маркетинг бүхий бараа, үйлчилгээний борлуулалт хийх зэрэг хөдөлмөр эрхлэлтийн олон хэлбэрийг дэмжих замаар эмэгтэйчүүд, оюутан, залуучууд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.

1.3.15 Ажил олгогчдын эрэлт, хэрэгцээнд нийцсэн, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийг бүрэн хангах мэргэжилтэн бэлтгэх нөхцөлийг бүрдүүлнэ.

1.3.16 Инновацад суурилсан гарааны бизнесийг дэмжинэ. Гарааны бизнесийг дэмжих эко системийг бүрдүүлнэ.

1.3.17 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх бодлого, зохицуулалтыг харилцан уялдуулсан ослын даатгалын тогтолцоог нэвтрүүлнэ.

1.3.18 Малын гаралтай түүхий эд боловсруулах, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, хөдөө аж ахуй, хүнд, хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлж, ажлын байр бий болгоно.

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН НАМЫН ХОРОО

1.3.19 Нийгмийн халамжийг зорилтот бүлэгт чиглүүлэн, хөдөлмөр эрхлэх сэдлийг төрүүлж, өрх, иргэнийг ядуурлаас гарахад дэмжлэг үзүүлнэ.

1.3.20 Ажлын байр шинээр бий болгох хувийн хэвшлийн санал, санаачилгыг дэмжиж, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх бодлогыг үргэлжлүүлнэ.

1.3.21 Өрхийн үйлдвэрлэлийг бүх талаар дэмжиж, багаoврын дэвшилтэт тоног төхөөрөмжийн мэдээллийг иргэдэд хүргэх, зуучлах, тоног төхөөрөмжийг түрээслэх, лизингийн зээлээр олгох үйлчилгээг хөгжүүлнэ.

## 1.4. НИЙГМИЙН ХАМГААЛАЛ

1.4.1 Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг бусдын адил бизнес эрхлэх, сурч, хөдөлмөрлөх, бие даан амьдрахад нь туслах, сэргээн засах, нийгмийн харилцаанд ороход туслан дэмжих зэргээр тэдний хэрэгцээнд нийцсэн олон талт мэргэжлийн үйлчилгээ үзүүлнэ.

1.4.2 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй ажиллах мэргэжилтэн, дохионы хэлний орчуулагч, тусгай сургуулийн багш, мэргэжилтнүүдийг бэлтгэх төлөвлөгөөт арга хэмжээ авч, нийгмийн баталгааг нь эрс дээшлүүлнэ.

1.4.3 Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэдэд зориулсан сэргээн засах, хөгжлийн цогцолбор төв байгуулан, тэдэнд хөдөлмөр эрхлэх дэд бүтэц, техник тоног төхөөрөмжийн таатай орчныг бүрдүүлнэ.

1.4.4 Хүүхдийг цахим халдлагаас хамгаалах эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

1.4.5 Хүүхдийг хүчирхийлэл, мөлжлөгөөс хамгаалах хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, мэргэжлийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.

1.4.6 Хүүхэд хамгаалал хөгжлийн чиглэлээр гаргасан санал санаачилгыг дэмжиж хамтран ажиллана.

1.4.7 Хөгжлийн бэрхшээлтэй хүний асран хамгаалагчдыг дэмжих бодлого хэрэгжүүлнэ.

1.4.8 Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэн нийгмийн амьдралд тэгш оролцох боломжийг нэмэгдүүлсэн үйлчилгээнд хөнгөлөлт, дэмжлэг үзүүлдэг болно.

## 1.5. СОЁЛ, УРЛАГ, СПОРТ

Соёлын биет ба биет бус өвийг хадгалан хамгаалах, сэргээн засварлах, түүнийг хамгаалан цуглуулагч, өвлөн тээгч нарыг сурталчлан дэмжиж, үндэсний агуулгатай дэлхийн сонирхлыг татахуйц үнэ цэнтэй өвийг хөгжүүлэх "Соёлын өв тээгч" орон нутгийн бодлогыг хэрэгжүүлнэ

1.5.1 Хүний нөөцийн чадавх сул, үйл ажиллагаа нь зогсонги соёл, урлагийн байгууламжуудыг олон нийтийн болгож, хөгжүүлнэ.

АРДЧИЛСАН НАМ
ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН НАМЫН ХОРОО

1.5.2 Чөлөөт өрсөлдөөний зарчимд нийцүүлэн мэргэжлийн соёл, урлагийн байгууллагуудад нэмэлт орлого олох боломж, нөхцөлийг бүрдүүлнэ.

1.5.3 Төрийн өмчийн оролцоо бүхий соёлын байгууллагуудад менежментийн шинэчлэл хийж, бие даасан байдлыг сайжруулна.

1.5.4 Мэргэжлийн урлагийн сургалтын байгууллага төгсөгч, дадлагажигчдад эзэмшсэн ур чадвараа хөгжүүлэх, уран бүтээлээ олны хүртээл болгоход дэмжлэг үзүүлнэ.

1.5.5 Соёлын өвийг хадгалан хамгаалах өвлөн уламжлуулах, баяжуулан хөгжүүлж буй биет бус өв тээгч нарыг урамшуулах тогтолцоог дэмжинэ.

1.5.6 Олимпизм, спорт, бие бялдрын хүмүүжил хөтөлбөрийг боловсруулж, сургалт, уриалга, аянуудыг бодлогоор дэмжин хэрэгжүүлнэ.

1.5.7 Хүн амд үзүүлэх биеийн тамир, спортын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.

1.5.8 Алхалт, спорт аялал, гүйлт, марафоныг бодлогоор дэмжин, сум орон нутаг, аймаг, улс, олон улсын хэмжээний уралдаан тэмцээнүүдийг зохион байгуулна.

1.5.9 Спортын салбарт амжилт гаргаж, уралдаан тэмцээнд амжилттай оролцсон спорт клуб, баг, тамирчдыг бодлогоор дэмжинэ.

1.5.10 Нийтийг хамарсан үндэсний болон нийтийн биеийн тамир, бүх нийтийн спортын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн ус байгууллагуудыг түшиглэн биеийн тамираар хичээллэгсдийг нэмэгдүүлнэ.

1.5.11 Үндэсний сур харваа, бөх, морины уралдааны уламжлалыг өв соёлын хадгалан хойч үедээ өвлүүлэн үлдээх төр, засгийн бодлогын хэмжээнд онцгойлон анхаарч, залгамж халааг бэлдэхэд дэмжиж ажиллана.

1.5.12 Үндэсний уламжлалт тоглоом, наадгайг хөгжүүлэхэд иргэдийн оролцоог хангах хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ.

1.5.13 Оюуны спортыг бодлогоор дэмжинэ.

1.5.14 Өвлийн спортыг аялал жуулчлалтай хослуулан бодлогоор дэмжинэ.

1.5.15 Нийтийн биеийн тамир, спортыг олны хүртээл болгож, энэ чиглэлээр санаачилга, амжилт гаргасан иргэн, гэр бүл, сум, баг, байгууллага хамт олныг бүх талаар дэмжинэ.



АРДЧИЛСАН НАМ
ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН НАМЫН ХОРОО

## Хоёр. ЭДИЙН ЗАСГИЙГ ЭРЧИМЖҮҮЛЭХ

Эдийн засгийн тогтвортой өсөлт иргэн бүрдээ хүрсэн, дундаж давхарга зонхилсон, ядуурал эрс буурсан, эдийн засгийн хөгжлийн бодлогын суурийг бүрдүүлж, дотоод хэрэгцээгээ өөрсдөө хангадаг, экспорт эрчимжсэн, хөрөнгө оруулалт, хуримтлалын чадавхаа бүрдүүлсэн, олон тулгуурт эдийн засагтай аймаг болно.

### 2.1 ЭДИЙН ЗАСАГ

2.1.1. Хэрэглэгчийн эрх ашгийг хангах зорилгоор эдийн засгийн өсөлтийг дэмжсэн бодлого, хувь хүний санаачилга, бизнес эрхлэх боломж, нийгмийн хариуцлагатай аж ахуй эрхлэлт, бие даасан зохицуулалтыг дэмжиж, хөгжүүлнэ.

2.1.2. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас санхүүжүүлэх бизнес,төсөл, арга хэмжээний жагсаалтыг шинэчилж, эдийн засгийн тэргүүлэх чиглэл, нийгмийн зорилтот бүлгийг харгалзан үздэг зарчмыг баримтална.

2.1.3. Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангийн эх үүсвэрийг нэмэгдүүлж, экспортын үйлдвэрлэлийг дэмжих бодлого гаргана.

2.1.4. "Өрх бүр баялаг бүтээгч" үндэсний хөтөлбөрийг үе шаттай хэрэгжүүлнэ.

2.1.5. Бизнес хөгжүүлэх төвөөр дамжуулан бизнес эрхлэгчдийг дэмжинэ.

2.1.6. Жижиг, дунд болон бичил үйлдвэрлэл эрхлэгчдийг гадаад зах зээлд гарах, хил орчмын худалдаанд идэвхтэй оролцоход нь дэмжлэг үзүүлнэ.

Эдийн засгийн тэргүүлэх чиглэлүүд



- Аж үйлдвэр
- Хөдөө аж ахуй
- Уул уурхай
- Аялал жуулчлал

**2.2 АЖ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН САЛБАР** Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдийг боловсруулах, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлэн, иргэдийн бодит орлогыг нэмэгдүүлнэ.

2.2.1 Инновац, өндөр технологи, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээ, дахин боловсруулах болон бүтээлч аж үйлдвэрлэлийг хөгжүүлэх хувийн хэвшлийн санал, санаачилгыг дэмжинэ

2.2.2 Төрийн худалдан авалтыг үндэсний үйлдвэрлэлийн бараа, бүтээгдэхүүний борлуулалтыг дэмжихэд чиглүүлнэ.

2.2.3 Малаас гарч буй түүхий эд, арьс шир, ноос ноолуур боловсруулах үйлдвэрлэлийн төвүүдийг бодлогоор дэмжинэ.

2.2.4 Жижиг, дунд үйлдвэрийн салбарыг кластераар хөгжүүлэх, кластерийн талаар баримтлах стратегийг дэмжиж ажиллана.

2.2.5 Аж үйлдвэрийн хамтын ажиллагааг дэмжих, гадаад улс орнуудын технологийн дэвшлийг ашиглах, нутагшуулах замаар болон өөрийн орны нөөц, чадавх, онцлогт тулгуурлан хөгжүүлэх бүтээгдэхүүн, үйлчилгээний чиглэлийг тодорхойлж, үйлдвэрлэлд нэвтрүүлнэ.

2.2.6 Одоо ашиглаж байгаа болон ашиглахад бэлэн байгалийн түгээмэл тархацтай ашигт малтмалын ордыг түшиглэн барилгын материалын үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

2.2.7 Ноос боловсруулах үйлдвэрийг дэмжиж, бүтээгдэхүүний шинэ нэр төрлийг нэмэгдүүлнэ. Үүнд ноосон бордоо, ноосоор хийсэн барилгын дулаалга гм.

**2.3 ХӨДӨӨ АЖ АХУЙ**

Хөдөө аж ахуйн салбарт боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих ноос, ноолуур, мах, махан бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүн, арьс, ширний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ, малынхаа тоо толгойг бэлчээрийн даацад тохируулах бодлогыг хэрэгжүүлнэ.

2.3.1.1 Мах, сүү, шувуу, зөгийний эрчимжсэн фермерийн аж ахуй эрхлэх иргэн, аж ахуйн нэгжийг хөрөнгө оруулалт, зээлийн бодлогоор дэмжинэ.

2.3.1.2 Хүлэмжийн аж ахуй, дуслын усалгаанд шаардлагатай нар, салхины сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээр хангах төсөл хэрэгжүүлнэ.

2.3.1.3 Өрх, байгууллага бүр хүлэмжийн аж ахуй эрхлэх санаачилгыг дэмжиж, шинэ ногооны нэр төрөл, хангамжийг сайжруулна.

2.3.1.4 Хамгаалагдсан хөрсний буюу шилэн, нийлэг хальсан хүлэмж, дарлага, туннелийн аж ахуй дагнан эрхлэх явдлыг дэмжиж, зоорь агуулахын аж ахуйн технологийн түвшинг сайжруулан хүртээмжийг нэмэгдүүлснээр хүнсний

ногооны хэрэглээний бүтэц, жилийн тогтвортой хангамжид чанарын өөрчлөлт гаргана

2.3.1.5 Хүнсний ногооны төрөлжсөн зоорь барих ажлыг дэмжинэ.

2.3.1.6 Онги, Дайргын гол, Дэлгэрэх булгийн дагуу түргэн ургацтай таримлын хүрээлэнг байгуулна.

2.3.1.7 Говийн сумдын ногоон байгууламж, цэцэрлэгжилтийг бодлогоор дэмжих

2.3.1.8 Нарны энерги, газрын нөөц, боломж өгөөжийг зохистой ашиглан, хучлагатай нөхцөлд далд хөрсний хүнсний ногооны үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх замаар эрт ургацын шинэ ногоог зах зээлд хүрэлцэх хэмжээгээр тасралтгүй нийлүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.

2.3.1.9 Хүлэмжийн аж ахуй эрхлэхэд шаардлагатай техник, технологи, үр материалаар хангах арга хэмжээг төлөвлөн, сумдын агропаркуудын хүлэмж, зоорийг бүрэн хүчин чадлаар нь ажиллуулах зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

2.3.1.10 Малчдын залгамж халааг бэлтгэх зорилгын хүрээнд "Залуу малчин өрх"-ийг дэмжин урамшуулах аймгийн хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлнэ.

2.3.1.11 "Малын эрсдэлийн сан"-г сум бүрд байгуулан малын эрүүл мэндийг хамгаалах, үүлдэр угсааг сайжруулах, бэлчээр, тэжээл, усан хангамжийг сайжруулах арга хэмжээг тухайн сангийн хөрөнгөөр шийддэг болно.

## 2.3 МАЛ АЖ АХУЙ

Мал аж ахуйн салбарыг эдийн засгийн үр ашигтай, орчин үеийн шинэ технологи, инновацад суурилж, хөгжүүлэн мэдлэг бүхий малчдыг малчин бизнесмен болгох замаар тогтвортой орлого бүхий хүчтэй дундаж давхаргыг тэлэх бодлого хэрэгжүүлнэ.

2.3.2.1 Малыг тооноос илүү чанарт шилжүүлж, малын төрлийг зохистой харьцаанд хүргэж, эдийн засгийн ашигтай, технологид суурилсан мал аж ахуйг бодлогоор дэмжинэ. Иргэдийн санаачилгад суурилсан "Чинээлэг малчин" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

2.3.2.2 Малыг вакцин, туулгад бүрэн хамруулан эрүүлжүүлэх ухаалаг хяналтын системийг нэвтрүүлнэ.

2.3.2.3 Малын үүлдэр угсааг сайжруулна.

2.3.2.4 Хүн амын хүнсний гол нэр төрлийн бүтээгдэхүүний дотоодын хэрэгцээг аюулгүй, чанартай хүнсээр хүртээмжтэй, тогтвортой хангах нөхцөлийг бүрдүүлнэ.

2.3.2.5 Байгалийн болон бэлчээрийн мал аж ахуйн гаралтай органик хүнс, хүнсний нэмэлт тэжээлийн үйлдвэрлэлийг дэмжиж, экспортын хэмжээг нэмэгдүүлнэ.

2.3.2.6 Хүнс, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний худалдааны орчныг сайжруулж, эко, ногоон, органик шошготой бүтээгдэхүүнийг олшруулан сав баглаа, боодлыг нэгдмэл стандарттай болгоно.

2.3.2.7 Хүн амын хүнсний аюулгүй байдлын бие даасан байдлыг хангах зорилтыг хэрэгжүүлж, монгол хүнд эрүүл хоол, хүнс хэрэглэх дадлыг төлөвшүүлэн шимт тэжээллэг хоол, хүнсний хангамж, хүртээмжийг нэмэгдүүлнэ.

2.3.2.8 Малчин өрх нь хүчин чадал өндөртэй техник, тоног төхөөрөмж ашиглах нөхцөлийг бүрдүүлнэ.

2.3.2.9 Малчдын хамтын оролцоонд тулгуурлан бэлчээр нутгийн тогтвортой ашиглалтыг хангаж, доройтсон бэлчээрийг сэргээнэ.

2.3.2.10 Бэлчээр хамгаалах зорилгоор мэрэгч амьтад болон байгаль орчинд сөрөг нөлөө ихтэй хортон шавжийг устгана.

2.3.2.11 Хөдөөгийн малчин өрхийг дэмжих "малжуулах хөтөлбөр"-ийг хэрэгжүүлнэ.

2.3.2.12 Малчдын хамтын оролцоонд тулгуурлан бэлчээр нутгийн тогтвортой ашиглалтыг хангаж, доройтсон бэлчээрийг сэргээх арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлнэ.

2.3.2.13 Малын гаралтай хоёр дахь түүхий эдийг хаягдалгүй боловсруулах, өндөр уургийн агууламжтай түүхий эд үйлдвэрлэх чиглэлд хөрөнгө оруулалтыг дэмжинэ.

2.3.2.14 Эрсдэл бүхий нөхцөлд эргэлтэд оруулах зорилготой өвс, тэжээлийн нөөцийн фондын тогтолцоог бий болгоно.

## 2.3 ГАЗАР ТАРИАЛАН

2.3.3.1 Газар тариалангийн бүс нутагт усалтын системийн менежментийг боловсронгуй болгож, тариалан эрхлэгч, хүнсний ногоо тариалагчдыг бодлогоор дэмжинэ.

2.3.3.2 Газар тариалангийн үйлдвэрлэлийн мэргэжлийн ажиллах хүчний хангамж, чадавхыг бэхжүүлэх чиглэлээр тусгай хөтөлбөр хэрэгжүүлнэ.

2.3.3.3 Газар зохион байгуулалтын болон байгаль орчны менежментийн төлөвлөгөөгөөр дамжуулан газрыг зохистой ашиглах, нөхөн сэргээх бодлого хэрэгжүүлнэ.

2.3.3.4 Үрийн аж ахуйн системийг боловсронгуй болгож, аж ахуйг сэргээн хөгжүүлж, хөрс, цаг уурын онцлогт тохирсон, баталгаат сортын үрийн хангамжийг нэмэгдүүлнэ.



АРДЧИЛСАН НАМ
ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН НАМЫН ХОРОО

2.3.3.5 Сэргээгдэх эрчим хүчийг ашигласан усжуулалтын систем, худгийн тоог нэмэгдүүлнэ.

2.3.3.6 Экспортод чиглэсэн өндөр ашиг шимтэй эрчимжсэн мал аж ахуйг газар тариалантай хослуулан хөгжүүлнэ.

2.3.3.7 Дотоодын тэжээл үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, бодлогоор дэмжинэ.

2.3.3.8 Газрын үржил шимийг хамгаалан зохистой ашиглаж, газар тариалангийн үйлдвэрлэлд орчин үеийн технологи, инновац нэвтрүүлнэ.

2.3.3.9 Орон нутгийн хөрс, цаг уурын онцлогт тохирсон ургамлын аж ахуйг төрөлжүүлэн хөгжүүлж, импортыг орлох органик брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэх санал санаачилгыг бүх талаар дэмжинэ.

2.3.3.10 Газар тариалангийн үйлдвэрлэлийн техникийн шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлж, орчин үеийн техник хангамжийн түвшнийг дээшлүүлнэ.

2.3.3.11 Эрдэс болон органик гаралтай бордооны дотоодын үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлж, хангамжийг нэмэгдүүлнэ.

2.3.3.12 Таримал ургамлын үр үржүүлгийн аж ахуйг цогцоор хөгжүүлж, үрийн сорт сорилт, чанарыг сайжруулж, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон, нутагшсан сортын үрийн хангамжийг нэмэгдүүлнэ.

2.3.3.13 Өрхийн тариаланг өргөжүүлэн, эрчимжүүлэн хөгжүүлж, "Эрүүл хүнс" хөтөлбөрийн зорилтыг бүрэн хэрэгжүүлнэ.

2.3.3.14 Өрхийн тариаланд ээлжлэн тариалах системийг нэвтрүүлэн хөрс болон таримлыг хамгаалах ажлын чанарыг сайжруулна.

2.3.3.15 Өрхийн тариалангийн гар ажиллагааг хөнгөвчлөх зорилгоор бага оврын техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг импортлохын зэрэгцээгээр дотооддоо үйлдвэрлэж байгаа иргэд, аж ахуйн нэгж байгууллагыг дэмжинэ.

2.3.3.16 Хүнсний ногоо, жимс, жимсгэнэ тариалдаг аж ахуйн нэгж, өрхүүдэд боломжтой бүх нөхцөлийг ашиглан худаг, гол, цас, борооны усыг хэмнэлттэй зарцуулах арга технологийг эзэмшүүлнэ.

2.3.3.17 Хүнсний ногооны таримлын бүтцийг олшруулан, сайжруулахад чиглэгдсэн арга хэмжээг үе шаттайгаар авч хэрэгжүүлнэ.

2.3.3.18 Жимс, жимсгэний аж ахуйг өргөжүүлэн хөгжүүлэх замаар хүн амын хүнсний бүтэц дэх жимс, жимсгэнийн хэрэглээг нэмэгдүүлнэ;

2.3.3.19 Жимс, жимсгэнэ боловсруулах үйлдвэр байгуулах санаачилгыг бодлогоор дэмжин, жимс, жимсгэнэ, чимэглэлийн ургамлын суулгацыг ургуулах үржүүлгийн газрыг байгуулах үүсгэл, санаачилгыг дэмжин хэрэгжүүлнэ.

2.3.3.20 Аймгийн хүн амын хүнсний хэрэгцээг өөрийн аймгийн хөрсөнд тариалсан бүтээгдэхүүнээр бүрэн хангах асуудлыг шийдвэрлэж, төмс, хүнсний ногооны

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
НАМЫН ХОРОО
9023041590

тариалалт, хураан авалт, хадгалалт, борлуулалтын кластрын сүлжээг бий болгоно.

## 2.4 УУЛ УУРХАЙ

2.4.3 Орон нутгийн хөгжил, эдийн засгийн өсөлтийг хангах хариуцлагатай уул уурхайг дэмжинэ.

2.4.4 Түгээмэл тархацтай ашигт малтмалыг зөвхөн судлагдаж, зөвшөөрөгдсөн талбайгаас ашиглуулж, нөхөн сэргээлт хийлгэх бодлого баримтална.

2.4.5 Баянтээгийн уурхайн менежментийг сайжруулж, ашиглалтын нөөцийг нэмэгдүүлэх, цахилгаан, дулааны станц барьж, сайжруулсан шахмал түлшний үйлдвэрийг өргөтгөх, өөрийн болон зэргэлдээх аймгуудыг сайжруулсан шахмал түлшний хэрэгцээг хангаж, агаарын бохирдлыг бууруулна.

2.4.6 Улсын болон хувийн хэвшлийн хөрөнгөөр уул уурхайн орд газруудад хийгдэх геологи, хайгуул судалгааны ажлыг дэмжинэ.

2.4.7 Уул уурхайн олборлолт болон байгалийн нөөц ашиглах салбарт төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагын түншлэлийг хөгжүүлж, нийгмийн хариуцлагын гэрээг хэрэгжүүлж, мэдээллийн ил тод байдлыг хангана.

2.4.8 Уул уурхайн болон барилгын материалын үйлдвэрүүдийн мэргэжилтэй ажилчдыг орон нутагт бэлтгэнэ.

2.4.9 Бичил уурхайн эрх зүйн орчныг боловсронгуй болгож, шаардлага хангасан зарим нөхөрлөл, хоршоог уул уурхайн олборлолтын аж ахуйн нэгж хэлбэрээр албажуулан хууль бус олборлогчдод тавих төрийн хяналтын тогтолцоог сайжруулна.

## 2.5 АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ

2.5.1 Өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр гаргасан санал санаачилга, хөтөлбөр, арга хэмжээг бодлогоор дэмжинэ.

2.5.2 Жуулчдад чанартай үйлчилгээ үзүүлэх аялал жуулчлалын дэд бүтцэд хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.

2.5.3 Аялал жуулчлалын зориулалттай авто замын сүлжээ, дэд бүтцийг хөгжүүлнэ.

2.5.4 Аялал жуулчлалын хувийн зөвлөгч гаргахын тулд хиймэл оюун ухаан ашигласан платформ нэвтрүүлнэ.

2.5.5 Спорт, эрүүл мэнд, явган алхалт, эко туризм зэрэг нүүдэлчний өв соёлыг сурталчлах аялал жуулчлалын төрөл хэлбэрүүдийг бодлогоор дэмжинэ.

2.5.6 Түүх соёлын дурсгал болон байгалийн үзэсгэлэнт газруудыг түшиглэсэн аялал жуулчлалыг соёлын цогц үйлчилгээтэй хослуулан хөгжүүлж соёл урлагийн брэнд бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлнэ

# Гурав. ДЭД БҮТЭЦ

Хот, хөдөөгийн хөгжлийн ялгааг арилгах тэнцвэртэй хөгжлийн бодлого хэрэгжүүлнэ. Бүс нутгийн эдийн засгийн өрсөлдөх чадвар, зах зээлийн нөхцөл байдалтай уялдуулан бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг шинэчилнэ.

3.1.1 Арвайхээр сумын цахилгаан, цэвэр, бохир усны инженерийн дэд бүтцийг шинэчлэн өргөтгөж, үерийн далан, суваг, борооны ус зайлуулах шугам сүлжээний ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж, ундны усны хоёр дахь эх үүсвэрийг ашиглалтад оруулахыг бодлогоор дэмжинэ. Аж үйлдвэрийн хөгжлийн бүсийг хүн амын нутагшил, суурьшил, дэд бүтэц ашигт малтмал, үндсэн түүхий эдийн нөөцөд үндэслэн байгуулна.

3.1.2 Гэр хорооллыг инженерийн дэд бүтэц (цэвэр ус, бохир ус ариутгах татуурга, интернэтийн шилэн кабель)-д холбож, халаалтыг төвлөрсөн болон сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэртэй амины орон сууц болгон дахин төлөвлөх ажлыг иргэдийн оролцоотой хэрэгжүүлж, амьдрах сууц байшингаа барихад урт хугацаатай, хүү багатай, орон сууцны ипотекийн зээлээр санхүүгийн дэмжлэг үзүүлж ажиллана.

3.1.3 Технологийн банк болон үйлдвэр технологийн паркуудыг хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар байгуулахыг дэмжинэ

3.1.4 Нийтийн тээврийн үйлчилгээний чанарыг сайжруулж хүртээмжийг нэмэгдүүлнэ

3.1.5 Хог хаягдлын төвлөрсөн цэгийг стандартын ландфиллын аргаар болон аюултай хог хаягдлыг түр хадгалах, устгах зориулалт бүхий байгууламж бий болгох зэргээр шийдвэрлэн, хог хаягдлыг дахин боловсруулах жижиг үйлдвэр байгуулна.

3.1.6 Үйлчилгээний газар, шинээр баригдаж байгаа барилга байгууламж, дугуйн болон явган хүний зам, гэрлэн дохиог олон улсын стандартын шаардлагад нийцүүлнэ.

3.1.7 Дулааны цахилгаан станцыг бүрэн ашиглалтад оруулна.

3.1.8 Сум, багийн төвүүдийг шинэчлэх төслийг үргэлжлүүлж, засгийн газраас хэрэгжүүлэх орон нутгийн авто замын сүлжээнд сумдыг холбох ажлыг эхлүүлнэ.

3.1.9 Орон нутгийн авто замын сүлжээний хүрээнд Арвайхээр–Хужирт 43.3 км авто зам тавина.

3.1.10 Чойр-Мандалговь-Арвайхээр 487.73 км авто зам; /Арвайхээр–Сант/

3.1.11 Гэр хорооллын цахилгаан эрчим хүчний хүчин чадлыг нэмэгдүүлнэ.

3.1.12 Сумдын төвд хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу инженерийн шугам сүлжээг бий болгон аж ахуйн нэгж, гэр хорооллын айл өрхүүдийг холбох, орон сууцжуулах нөхцөлийг бүрдүүлж, авто болон явган хүний зам, гэрэлтүүлэг, ногоон

байгууламж, үерээс хамгаалах далан сувгийг төлөвлөлтийн дагуу байгуулах бодлого, чиглэлийг дэмжиж ажиллана.

3.1.13 Газар зохион байгуулалтын төлөвлөлт, газрын кадастр, үнэлгээ, газрын мониторинг, биржийн байнгын ажиллагаатай системийг хөтөлж, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах

3.1.14 Аймаг, сумын төвүүдийг орон сууцжуулах бодлогыг ипотекийн зээлийн бодлоготой уялдуулан хэрэгжүүлнэ.

3.1.15 Гэр бүлийн хэрэгцээний газраа өмчилж авч чадаагүй, аймаг сумын төвийн өрхүүдэд газрыг нь өмчлүүлэх арга хэмжээг бодлогоор хэрэгжүүлнэ.

## 3.2 ЭРЧИМ ХҮЧ

3.2.1 Баянтээгт 36МВт-ын дулааны цахилгаан станц барьж, сайжруулсан шахмал түлшний үйлдвэрлэлийг дэмжинэ.

3.2.2 Аймгийн төвийн дулааны станц, дулааны сүлжээ байгуулах ажлыг хэрэгжүүлж ашиглалтад оруулна.

3.2.3 Шинэ бүтээн байгуулалт, шинэ суурьшлын бүс, хот суурин газрыг дулааны эрчим хүчээр хангах техник, технологийн боломжийг бүрдүүлнэ.

3.2.4 "Шинэ зууны малчин" хөтөлбөр хэрэгжүүлж малчин өрхүүдийг хүчин чадал өндөртэй цахилгаан хэрэгсэл ашиглах боломжоор хангаж, бодлогоор дэмжинэ.

3.2.5 Аймгийн бүх сумдын эрчим хүчний найдвартай байдлыг хангах бодлого баримталж, цахилгаан, дулааны шинэ технологийн бага оврын станцуудын төсөл, хөтөлбөр хэрэгжүүлнэ.

3.2.6 Сэргээгдэх эрчим хүчний чиглэлийн мэргэжилтэн, судлаачдад болон тус салбарт үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудыг дэмжих, шинэ техник технологийг танилцуулах, сурталчлах, мөн салбарын тулгамдсан асуудлуудыг оновчтой шийдэл, гарцыг хамтран тодорхойлох, бүс нутаг, аймаг, сумдын хэмжээнд нийгэм, эдийн үр ашигтай төсөл, хөтөлбөрүүдийг дэмжинэ.

## 3.3 МЭДЭЭЛЭЛ, ХАРИЛЦАА

3.3.1 Улсын чанартай авто зам дагуу болон алслагдсан багийн үүрэн телефоны сүлжээний өргөтгөлийг хийх

3.3.2 Үүрийн телефоны операторуудтай хамтран орон нутагт өндөр хурдны интернэт үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.

3.3.3 Эрүүл мэндийн байгууллагууд, эмнэлгийн цахим системийг хөгжүүлнэ.

3.3.4 Сургууль, цэцэрлэгийн сургалтын удирдлагын системийг хөгжүүлнэ.

3.3.5 Онлайн бизнес үйлчилгээг нэвтрүүлэх, дижитал мэдээллийн самбартай болно

АРДЧИЛСАН НАМ
ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН НАМЫН ХОРОО

3.3.6 Хүний хөгжлийг дэмжсэн, үр дүн, үр нөлөөтэй цахим засаглалыг төлөвшүүлэх, гар утасны аппликейшн хөгжүүлнэ.

3.3.7 Олон нийтийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэргээс сэргийлэх "SafeUV" аппликейшн хөгжүүлнэ.

3.3.8 Арвайхээр сумын нийтийн эзэмшлийн талбай, Хархорин аялал жуулчлалын гудамжинд "Free Wifi Zone" бий болгох бодлогыг дэмжин ажиллаж хэрэгжүүлнэ.

3.3.9 Аймаг, сумдын цаг уурын станцуудын шуурхай мэдээллийг иргэд, малчдад хүргэх цахим төслийг боловсруулан хэрэгжүүлнэ.

**3.4 БАРИЛГА**

3.4.1 Шаардлагатай барилга, байгууламж, төсөл арга хэмжээний техник эдийн засгийн үзүүлэлтийг жил бүр үе шаттайгаар боловсруулна.

3.4.2 Орон сууцжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх замаар барилгын салбарт ажиллагсдыг бодлогоор дэмжинэ.

3.4.3 Залуу гэр бүл, гэр хорооллын айл өрхүүд, бусад зорилтот бүлгийн иргэдэд чиглэсэн "тохилог орон сууц" хөтөлбөр хэрэгжүүлнэ.

3.4.4 Амины орон сууц болон хуучин орон сууцны дулаан алдагдлыг бууруулах бодлого хэрэгжүүлнэ.

3.4.5 Гэр хорооллын дэд бүтцийг шийдэж, айл бүрийг хашаандаа сайхан амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.

3.4.6 Барилгын материалын үйлдвэрүүдийг байгуулан ажиллуулна.

3.4.7 Шинэ технологи, орон нутгийн түүхий эдэд тулгуурласан барилгын материалын үйлдвэрлэлийг дэмжиж ажиллана.

## Дөрөв. САЙН ЗАСАГЛАЛ

**4.2. ИРГЭНДЭЭ ҮЙЛЧИЛДЭГ ЗАСАГЛАЛ**

- Хүний заяагдмал эрхийг хамгаалах, иргэдэд хүний эрхийн талаар ойлголт өгөх, сурталчлан таниулах үйл ажиллагааг дэмжинэ.
- Хууль сурталчлах, таниулах ажлын чанарыг дээшлүүлж, олон нийтэд хууль зүйн мэдээллийг шуурхай, үр дүнтэй хүргэх тогтолцоог сайжруулна.
- Хүний заяагдмал эрхийг зөрчсөн, ялгаварлан гадуурхсан хуулийн заалт, зохицуулалтыг таниулах нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулна
- Иргэн, аж ахуйн нэгжийн төрөөс авах үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлнэ.
- Бүх шатны төрийн албан хаагчдыг эрхэлдэг ажлынхаа чиглэлээр сурч боловсрохыг дэмжиж, жил бүр сургалтад хамруулна.

АРДЧИЛСАН НАМ
ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН НАМЫН ХОРОО

- Газрын төлөвлөлт, олголтын орчинд реформ хийж, газар олгох, ашиглах, эзэмших, өмчлөх үйл ажиллагааг ил тод болгоно.
- Төрийн үйлчилгээнд хувийн хэвшил, иргэний оролцоот үнэлгээ, хариуцлагын тогтолцоог нэвтрүүлнэ.
- Төрийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагааны давхардлыг арилгах, нэгтгэх замаар бүтэц, зохион байгуулалтыг оновчтой, цомхон болгоно.
- Төрийн байгууллага, нийгэм, эдийн засаг, соёлын хүрээнд жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, бүх түвшинд жендерийн бодлого хэрэгжүүлнэ.
- Төрийн үйл ажиллагаа, төсвийн зарцуулалт, төрийн өмчит аж ахуйн нэгжүүдэд тавих иргэний болон хөндлөнгийн хяналтыг нэмэгдүүлнэ
- Иргэд сайн дураар эрхээ шаардан жагсаал, цуглаан хийхэд зөвшөөрөл авдаг байдлыг халж, урьдчилан мэдэгдсэнээр жагсаал, цуглаан хийх эрхийг нээлттэй болгон хуульчилна.
- Авилга албан тушаалын гэмт хэрэг, авилгаас олсон орлогыг шууд хураан авч улсын төсөвт төвлөрүүлэн хууль зүйн шийтгэлийг эрчимжүүлж, төрийн өндөр албан тушаалтны зарлага орлогын албан татвар, төлөлтийг ил болгон хянадаг тогтолцоог бүрдүүлж хохирлыг барагдуулах механизмыг сайжруулна.
- Сонгуулийн авлига, улс төрийн намаар дамжин төрд орж ирэх авлигын тойргийг таслан зогсоох арга хэмжээ авч, авлигын эсрэг улс төрийн шинэ соёл үүсгэнэ. Сонгуулийн луйвраас урьдчилан сэргийлэх хуулийг хэрэгжүүлнэ.
- Төсвийн зардлыг ач холбогдлоор нь эрэмбэлэх зарчимд шилжиж, үрэлгэн зардлыг багасган хэмнэлтийн горимыг хэрэгжүүлж, аймгийн төсвийн чадавхыг нэмэгдүүлнэ.
- Төсвийн ил тод байдлыг хангах шаардлагын дагуу Шилэн дансанд мэдээллийг тогтмол байршуулж, ил тод хяналттай төсвийг бий болгоно.
- Төрийн албан хаагчдын цалин хөлсийг ажлын байранд өнгөрүүлсэн хугацаагаар бус ажлын үр дүнгээр тооцдог аргачлалыг нэвтрүүлнэ.

## Тав. АЮУЛГҮЙ, НОГООН ӨВӨРХАНГАЙ

Эко системийн тэнцвэрт байдлын алдагдал, байгалийн нөөц баялгийн зүй бус ашиглалтыг зогсоох, цөлжилтийг сааруулах, "ногоон байгаль" бодлогыг хэрэгжүүлэн байгалийн жам өсоор сэргэх боломжийг дээшлүүлэх замаар хүрээлэн буй орчны тогтвортой байдал, ногоон хөгжлийг дэмжин хүний амьдралын чанарыг сайжруулна.

- Орчноо ногооруулсан иргэд, аж ахуйн нэгжийг урамшуулах тогтолцоог бий болгоно.
- Гамшиг, аюулаас хамгаалах бүтэц бий болгож, үйл ажиллагааг мэргэжлийн байгууллагын болон орон нутгийн иргэдийн хамтын тогтолцоотой болгоно.

АРДЧИЛСАН НАМ
ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН НАМЫН ХОРОО

- Төв суурины эрсдэл бүхий газруудыг камержуулж, цагдаагийн байгууллагатай шууд, хялбар байдлаар холбогдох тоноглол хийсэн "ногоон бүс" буюу аюулгүй бүс бий болгох ажлыг дэмжинэ.
- Хүнсний захуудад баримталдаг ариун цэвэр, аюулгүй байдлын стандартыг шинэчилж, чанд мөрдүүлнэ.
- Хүн амыг эрүүл, аюулгүй хүнсээр хангахад чиглэгдсэн хүнсний стандартыг шинэчлэн тогтооно.
- Эмнэлгүүдэд хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан дэд бүтэц, орчин бий болгоно
- Эко системийн тэнцвэрт байдлыг хадгалах, ой, рашаан, булгийг хамгаалах чиглэлээр өөрийн хөрөнгөөр нөхөн сэргээсэн иргэн, аж ахуйн нэгжид төрөөс урамшуулал олгох эрх зүйн орчныг бүрдүүлнэ.
- Ой болон бэлчээрт хөнөөл учруулж буй шавж, мэрэгч амьтадтай байгальд ээлтэй аргаар тэмцэж, энэ чиглэлээр хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.
- Цөлжилтөд хүчтэй өртсөн газрын доройтлыг бууруулах, нөхөн сэргээх арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- Цөлжилттэй тэмцэх шинэ технологи нэвтрүүлж, олон улсын хамтын ажиллагааг эрчимжүүлнэ.
- Цөлжилттэй тэмцэх ажлын хүрээнд сум бүрд 50-100 га ногоон байгууламж бий болгоно.
- Иргэдийн мод тарих санаачилгыг дэмжиж, бүртгэлийг цахимжуулан урамшууллын бодлогыг хэрэгжүүлнэ.
- Говь, хээрийн бүсэд үерийн усыг тогтоон барих далан, шингээх худаг, нэвчүүлэх цөөрөм, хөв байгуулах замаар усны нөөц баялгийг арвижуулах, нөхөн сэргээх технологи нэвтрүүлнэ.
- Бэлчээрийн ургамлын сэргэх чадавхид суурилсан менежментийг нэвтрүүлнэ.
- Гол горхи, булаг шандны эх болон цөлжилт, хөрсний элэгдэлд орсон газруудад мод тариалж аймгийн ойн сангийн хэмжээг нэмэгдүүлнэ.
- Байгаль орчинд ээлтэй эко түлш, сэргээгдэх эрчим хүч болон цахилгаан халаагуурын ашиглалтыг нэмэгдүүлэх, дулааны цахилгаан станцыг ашиглалтад оруулах замаар аймгийн төвийн агаар, хөрсний бохирдлыг 50 хүртэл хувь бууруулна.
- Аймгийн төвийг тойрсон ойн зурвасыг арчилж, сэргээн хамгаалж ургуулахын зэрэгцээ сум суурингуудыг ногоон зурвастай болгоно.
- Арвайхээр хотын цэвэр усны шугамын шаардлагатай хэсгүүдийг шинэчилж, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн стандарт шугамтай болгоно.

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН АРДЧИЛСАН НАМ**

АРДЧИЛСАН НАМ
ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН НАМЫН ХОРОО

БАЯНГОЛ СУМЫН АРДЧИЛСАН НАМЫН ХОРООНД

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, П.Гэндэнгийн гудамж,
5 дугаар баг, Арвайхээр сум, Өвөрхангай аймаг, 62173,
Утас/Факс: (976) 7032 3253,
Цахим шуудан: uvurkhangai@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2016.04.17 № 303

танай ____________-ны №____________-т

Дүгнэлт хүргүүлэх тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх заалт, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5 дахь хэсгийг үндэслэн Баянгол сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгуульд оролцох Баянгол сумын Ардчилсан намын хорооны Сонгуулийн мөрийн хөтөлбөр, хандивын тайланд хийсэн аудитын дүгнэлтийг хүргүүлж байна.

Хавсралт 22 хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР О.БАТЖАРГАЛ

6225030558

D:\Auditiin gazar\baiguullagiin dotood barimt\A4

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
Нутгийн удирдлагын ордон, П.Гэндэнгийн гудамж,
5 дугаар баг, Арвайхээр сум, Өвөрхангай аймаг, 62173,
Утас/Факс (976) 7032 3253,
Цахим шуудан: uvurkhangai@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.04.17 № 165

танай ____________-ны №____________-т

АРДЧИЛСАН НАМЫН БАЯНГОЛ СУМЫН ХОРООНД

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд заасан шаардлагад нийцсэн талаарх дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3, 5.4-т заасны дагуу Төрийн аудитын байгууллага Баянгол сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгуульд оролцох Ардчилсан намын Баянгол сумын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж дүгнэлт гаргалаа.

## Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Баянгол сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгуульд оролцох Ардчилсан намын Баянгол сумын хороо нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

## Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь Баянгол сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгуульд оролцох Ардчилсан намын Баянгол сумын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны

6225020402

төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

**Дүгнэлт**

Ардчилсан намын Баянгол сумын хорооны Баянгол сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Ардчилсан намын Баянгол сумын хорооны мөрийн хөтөлбөр (16....хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Баянгол сумын Сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР О.БАТЖАРГАЛ

## БАЯЛАГТАА ЭЗЭН БАЯНГОЛ

## СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

### АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ, ДҮҮРГИЙН ИТХ-ЫН СОНГУУЛИЙН 2024 ОНЫ СОНГУУЛЬД ОРОЛЦОХ ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН БАЯНГОЛ СУМЫН АРДЧИЛСАН НАМЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

Монгол Улсын тусгаар тогтнол, Үндэсний эрх ашиг, Үндсэн хуульт Ардчиллыг хамгаалан бэхжүүлэх, хувь хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, хуулийн засаглал, чөлөөт зах зээл, иргэний нийгмийн зарчимд суурилсан тогтвортой хөгжлийн төлөө Монгол улсын урт хугацааны хөгжлийн баримт АЛСЫН ХАРАА 2050 хөтөлбөрт Монгол хүн бүр хүсэл мөрөөдөлтэй, өрх бүр аз жаргалтай амьдрах хөгжлийн боломжийг дэмжсэн, иргэд нь эрх чөлөөтэй, эрх тэгш, хариуцлагатай, Ардчилсан Монгол Улсыг хөгжүүлэхийг **ЭРХЭМ ЗОРИЛГО** болгож

1. Монгол хүний эрх, эрх чөлөө, бие даасан байдлыг хангах
2. Хувийн өмч, өрсөлдөөнт зах зээл, төрийн хязгаарлагдмал оролцоо, хуулийн засаглалыг хөгжүүлэх
3. Үндэсний өв уламжлал, түүх соёлоо дээдлэн үнэт зүйлээ болгон тунхагласан

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН БАЯНГОЛ СУМЫН АРДЧИЛСАН НАМ 2024-2028 оны аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуульд оролцох "**БАЯЛАГТАА ЭЗЭН БАЯНГОЛ**" мөрийн хөтөлбөрөө Та бүхэндээ толилуулж байна.

ГАРЧИГ

Нэг. ХУВЬ ХҮНИЙ ХӨГЖИЛ, ЭРХ ЧӨЛӨӨ

1.1 ӨРСӨЛДӨХ ЧАДВАРТАЙ БОЛОВСРОЛ

1.2 ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

1.3 ХҮН АМЫН ХӨГЖИЛ, ХҮН, ӨРХ ГЭР БҮЛ

1.4 АЖЛЫН БАЙР ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

1.5 НИЙГМИЙН ХАМГААЛАЛ

1.6 СОЁЛ, УРЛАГ, СПОРТ

Хоёр. ХҮРТЭЭМЖТЭЙ ЭДИЙН ЗАСАГ

2.1 ӨСӨЛТИЙН БОДЛОГО ЖИЖИГ ДУНД БИЗНЕС

2.2 ДЭД БҮТЭЦ

2.3 АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ

2.4 ХҮНСНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ

Гурав. ЭЗЭН МОНГОЛ

3.1 ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛ, "ШИНЭ ХӨДӨӨ" ХӨТӨЛБӨР

3.2 "ЧИНЭЭЛЭГ МАЛЧИН" ХӨТӨЛБӨР

3.3 БЭЛЧЭЭР АШИГЛАЛТ

3.4 МАЛ АЖ АХУЙ

3.5 ГАЗАР ТАРИАЛАН

Дөрөв. ХУУЛЬТАЙ МОНГОЛ

4.1 ИРГЭНДЭЭ ҮЙЛЧИЛДЭГ ЗАСАГЛАЛ

Тав. АЮУЛГҮЙ, АМГАЛАН МОНГОЛ

5.1 БАЙГАЛЬ ОРЧНЫ ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ

## Нэг. ХУВЬ ХҮНИЙ ХӨГЖИЛ, ЭРХ ЧӨЛӨӨ

### 1.1 ӨРСӨЛДӨХ ЧАДВАРТАЙ БОЛОВСРОЛ

Хүн амын тогтвортой өсөлтийг хангаж, хүн бүрийг эрдэм боловсрол төгс, хөдөлмөрч, бүтээлч сэтгэлгээтэй, эрүүл амьдралын хэв маягийг хэвшил болгосон, БАЯНГОЛ нутгийнхаа байгаль, түүх соёл, уламжлалаараа бахархсан ба тэгш хүмүүжигээр төлөвшүүлэн, хангалуун сайхан амьдрах эрхийг дээдэлсэн хувь хүний хөгжлийн бодлого хэрэгжүүлнэ. Нийгмийн халамжийн үйлчилгээг зөвхөн зорилтот бүлэгт чиглүүлнэ.

- 1.1.1 Хүүхэд бүрийг хөгжүүлж, бүтээлч сэтгэлгээтэй, өөртөө итгэлтэй, эх нутгийнхаа байгаль, түүх, үндэсний хэл соёл, уламжлалаар бахархдаг хүмүүжил олгоно.
- 1.1.2 Хүүхэд гэр бүл, цэцэрлэг, сургуулийн орчинд эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх, орчны эрүүл мэндийг сайжруулах бодлогыг нийгмийн эрүүл мэндийн үндсэн чиглэл болгоно.
- 1.1.3 Сурагчдын сурах орчинг сайжруулж, анги танхимыг тохижуулна.
- 1.1.4 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг соёлын үйл ажиллагаанд идэвхтэй оролцуулах, тэдний авьяас хөдөлмөр бүтээлийг дэмжиж ажиллана.
- 1.1.5 Багш нарын мэдлэг, ур чадварыг тухай бүрд нь дээшлүүлж, давтан сургахад орон нутгийн төсвийн санхүүжилтээс дэмжлэг үзүүлэх ажлыг эхлүүлнэ.

### 1.2 ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

- 1.2.1 Эх хүүхэд, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 1.2.2 Иргэдийн халдварт болон халдварт бус өвчлөл, эх болон нярайн эндэгдлийг бууруулж, урьдчилан сэргийлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулна.
- 1.2.3 Эрүүл мэндийн төвийн стандартыг хангуулж, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангана.
- 1.2.4 Хүнийг өвдөхөөс нь өмнө урьдчилан сэргийлэх үзлэг, оношлогоог өрх гэрийн түвшинд тогтмол хийдэг эрүүл мэндийн үйлчилгээний шинэ хэлбэрийг бий болгоно.
- 1.2.5 Иргэн бүрийг насны бүлэгт нь тохирсон урьдчилан сэргийлэх үзлэг, оношлогоонд хамруулна.
- 1.2.6 Эмч нарын мэргэжил, боловсролыг тасралтгүй дээшлүүлэхэд орон нутгийн төсвөөс дэмжлэг үзүүлнэ.
- 1.2.7 Улирал бүр эрүүл мэндийн явуулын үзлэг оношилгоо хийж, сургалтыг тогтмол зохион байгуулна.

## 1.3 ХҮН АМЫН ХӨГЖИЛ, ӨРХ ГЭР БҮЛ

1.3.1 Хүүхэд залуучуудын хөгжлийн төв байгуулж хүүхэд, залуучууд цагийг зөв боловсон өнгөрүүлэх орчин нөхцөлийг нэмэгдүүлнэ

1.3.2 Хүүхдийн хүмүүжил, төлөвшлийн асуудалд онцгой анхаарч, цахим тоглоомын донтолт, мансуурлаас урьдчилан сэргийлж хүүхдийг хүмүүжүүлэх олон талт ажлыг зохион байгуулна

1.3.3 Гэр бүлийн гишүүн бүрд гэр бүлийн боловсрол олгох, ажил хөдөлмөр эрхлэх сонирхол, бизнесээ хөгжүүлэх амьдрах орчноо хамтдаа сайжруулах, мэдлэг ур чадварын сургалт, зөвлөмжөөр хангагдах боломжийг орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан хэрэгжүүлнэ

1.3.4 Хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх, дарамт, мөлжлөгийн бүх хэлбэрээс хамгаалах хуулийн хэрэгжилтийг сайжруулна

1.3.5 Хүүхдийг цахим мэдээллийн халдлагаас хамгаалах, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлнэ

## 1.4 АЖЛЫН БАЙР, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

1.4.1 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежментийг сайжруулахад чиглэсэн бодлого хэрэгжүүлнэ

1.4.2 Хөдөлмөрийн зах зээл дээр эрэлтийн судалгааны чанарыг сайжруулж, хэрэгцээтэй байгаа ажил, мэргэжлийг эдийн засгийн салбар, ажил мэргэжлээр нарийвчлан гаргаж, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын элсэлттэй нягт уялдуулна

1.4.3 Баянгол үйлдвэрлэлийн төв байгуулж хоршоодын бизнес эрхлэх боломжийг нэмэгдүүлнэ

## 1.5 НИЙГМИЙН ХАМГААЛАЛ

1.5.1 Малчдын нийгмийн даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлж, тэдний нийгмийн баталгааг хангана

1.5.2 Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулна

1.5.3 Шинээр ирсэн болон орон байр шаардлагатай төрийн албан хаагчдад ашиглалтгүй байгаа байруудыг засварлаж орон байраар хангана

1.5.4 Сумын төвийн худгуудад ус цэвэршүүлэгч төхөөрөмж байрлуулна

## 1.6 СОЁЛ, УРЛАГ, СПОРТ

1.6.1 Уламжлалт ёс соёлоо бодлогоор дамжин монгол хүнийг төлөвшүүлэхэд онцгойлон анхаарна

1.6.2 Соёлын биет ба биет бус өвийг хадгалан хамгаалах, сэргээн засварлах, түүнийг хамгаалагч, өвлөн уламжлагч нарыг сурталчлан дэмжиж, үндэсний агуулгатай дэлхийн сонирхлыг татахуйц үнэ цэнтэй өвийг хөгжүүлнэ

1.6.3 Түүх соёлын дурсгалт газрын хамгаалалтыг сайжруулж, соёлын өвийг хамгаалагч, хариуцагч нарын урамшууллыг нэмэгдүүлнэ

1.6.4 Спортын улс, бүсийн хэмжээний уралдаан тэмцээнийг зохион байгуулахад дэмжлэг үзүүлнэ. Улс бүс, олон улсын тэмцээнд оролцох багш тамирчдын зардалд орон нутгийн зүгээс дэмжлэг үзүүлдэг тогтолцоог бий болгоно.

1.6.5 Улсын болон олон улсын тэмцээнд оролцох эрх авсан тамирчдад нэг удаагийн дэмжлэг олгох тогтолцоог бүрдүүлнэ.

## Хоёр. ХҮРТЭЭМЖТЭЙ ЭДИЙН ЗАСАГ

### 2.1. ӨСӨЛТИЙН БОДЛОГО ЖИЖИГ ДУНД БИЗНЕС

2.1.1 Хөрөнгө дэмжих сангийн зээлийг үйл ажиллагаа явуулж байгаа хоршоодод тэгш хүртээмжтэй, ялгаварлалгүйгээр олгоно.

2.1.2 Нутгийн брэнд бүтээгдэхүүн бий болгоход бодлогоор дэмжинэ.

2.1.3 Ажиллах хүчнийг нэмэгдүүлэх, ядуурлыг бууруулах, ажлын байр олноор бий болгохыг нэн тэргүүний зорилт гэж үзэн шинэ ажлын байрыг бий болгох бүтээн байгуулалт, бизнесийн төслүүдийг бүх талаас дэмжиж хөгжүүлнэ.

2.1.4 Малын гаралтай түүхий эдийг боловсруулах, бүтээгдэхүүн үйлдвэрлэх жижиг аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлэн ажлын байрыг бий болгохыг дэмжинэ.

2.1.5 Орон нутгийн аж ахуй нэгж, компаниудын чадавх, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх төслүүдийг дэмжинэ.

2.1.6 Мал аж ахуй, газар тариалан, [illegible], зөгийн аж ахуйд суурилсан орон нутгийн онцлог шинэ брэнд бүтээгдэхүүний бизнес загвар хөгжүүлэхийг дэмжинэ.

2.1.7 Иргэд, орон нутаг, олон нийтийн оролцоо, олон улсын байгууллагуудтай хамтран ногоон хөгжлийн бодлого хэрэгжүүлж, байгаль орчныг нөхөн сэргээнэ.

### 2.2. ДЭД БҮТЭЦ

2.2.1 Үүрэн телефоны сүлжээний өргөтгөл, хүртээмжийг нэмэгдүүлнэ.

2.2.2 Стандартад нийцсэн камерын системтэй болгоно.

2.2.3 Сумын төвийн гэрэлтүүлгийг сайжруулж, шинэчлэл хийнэ.

2.2.4 Арвайхээр-Баянголыг холбох хатуу хучилттай авто зам барих ажлыг холбогдох байгууллагад уламжилж шийдвэрлүүлнэ.

2.2.5 Явган хүний зам, ногоон байгууламж, үерээс хамгаалах далан сувгийг төлөвлөлтийн дагуу байгуулна.

2.2.6 "Эко хаус" хороолол барих арга хэмжээг хэрэгжүүлнэ.

2.2.7 Сумын төвийн халаалтын нэгдсэн системийг шинэчлэнэ.

### 2.3. АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ

2.3.1 Монгол ахуй сурталчлах орон нутгийн онцлогт нийцсэн аялал жуулчлалын хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.

## 2.4 ХҮНСНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ

2.4.1 Хүн амын гол нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүний дотоод хэрэгцээг чанартай хүнсээр хүртээмжтэй хангаж, дотоод зах зээл дэх хүнсний нийлүүлэлтийн сүлжээнд аюулгүй байдлын тогтолцоог нэвтрүүлнэ.

2.4.2 Сүү цагаан идээ боловсруулах үйлдвэр барих санал санаачилгыг бодлогоор дэмжиж ажиллана.

# Гурав. ЭЗЭН МОНГОЛ

## 3.1 ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛ, ШИНЭ ХӨДӨӨ ХӨТӨЛБӨР

3.1.1 Бэлчээрийн менежментийг сайжруулна.

3.1.2 Бэлчээрийн болон хүн амын усан хангамжийг сайжруулна.

3.1.3 Багуудад мал эмнэлэг, үржлийн ажил үйлчилгээний төв барина.

3.1.4 Жижиг дунд үйлдвэрлэлийг бүх талаар дэмжинэ.

## 3.2 "ЧИНЭЭЛЭГ МАЛЧИН" ХӨТӨЛБӨР

3.2.1 Мал аж ахуйн салбарыг эдийн засгийн үр ашигтай, орчин үеийн шинэ технологи, инновацад суурилж хөгжүүлэх мэдлэг бүхий малчдыг "Малчин бизнесмэн" болгох замаар тогтвортой орлого бүхий хүчтэй дундаж давхаргыг тэлэх бодлого хэрэгжүүлнэ.

3.2.2 Малчдын орлогыг нэмэгдүүлэх зорилгоор сүү цагаан идээ үйлдвэрлэж буй иргэдийг олон нийтэд сурталчилан таниулж, үзэсгэлэн худалдаанд тогтмол хамруулна.

3.2.3 Мал, малын гаралтай бүтээгдэхүүний чанарт анхаарч, үнэ цэнийг нэмэгдүүлэх замаар малчдын орлогыг нэмэгдүүлнэ.

## 3.3 БЭЛЧЭЭР АШИГЛАЛТ

3.3.1 Малчдын хамтын оролцоонд тулгуурлан бэлчээр нутгийн тогтвортой ашиглалтыг хангаж, доройтсон бэлчээрийг сэргээх арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлнэ.

3.3.2 Бэлчээр хамгаалах зорилгоор мэрэгч болон байгаль орчинд сөрөг нөлөө ихтэй хортон шавьж устгах ажлыг зохион байгуулж хийнэ.

3.3.3 Отор хийсэн малчдын асуудлыг сум хоорондын түвшинд шийдэж өвөлжилт, хаваржилтын асуудлаар цогц арга хэмжээ авна.

3.3.4 Бэлчээрийн нөөцийг нэмэгдүүлж ногоон тэжээл тариалах талбайг нэмэгдүүлнэ.

3.3.5 Бэлчээрийн олон наст ургамал тариалах иргэдийг дэмжиж ажиллана.

## 3.4 МАЛ АЖ АХУЙ

3.4.1 Малын чанар, үүлдэр, угсааг сайжруулах эдийн засгийн ашигтай технологид суурилсан мал аж ахуйг бодлогоор дэмжинэ.

3.4.2 Хөдөөгийн малчин өрхийг дэмжих "Малжуулах хөтөлбөр"-ийг хэрэгжүүлнэ.

3.4.3 Гахай, шувууны аж ахуй эрхлэх, өсгөн үржүүлэх санаачилгыг дэмжинэ.

3.4.4 Малын үүлдэр угсаа сайжруулах тал дээр анхааран ажиллана.

3.4.5 Баг тус бүрийг малын эмчтэй болгож, мал эмнэлгийн чанар хүртээмжийг сайжруулна.

3.4.6 Баг бүрийг хариуцсан мал эмнэлгийн чанар хүртээмжийг сайжруулж баг бүрд мал угаалгын дун машин авч паразит өвчнөөс урьдчилан сэргийлнэ.

3.4.7 Сумын өвсний фондын салбаруудыг баг бүрт байгуулж, өвс тэжээлийн нөөц бүрдүүлнэ.

3.4.8 Сумын төвийн өвсний фондыг өргөтгөж саравч барина.

3.4.9 Мах, махыг зах зээлд борлуулах сүлжээ бий болгоно.

## 3.5 ГАЗАР ТАРИАЛАН

3.5.1 Малын тэжээл тарих тариалангийн талбайг өргөтгөнө.

3.5.2 Малын тэжээл үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх бодлогоор дэмжинэ.

3.5.3 Орон нутгийн онцлогт тохирсон газар тариалангийн бодлогын хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.

3.5.4 Цөлжилттэй тэмцэх зорилгоор мод тарих ажлыг эхлүүлнэ.

3.5.5 Ногоон зээл, төслүүдэд хамрагдах ажлыг холбогдох байгууллагад уламжилж шийдвэрлүүлнэ.

3.5.6 Өрхийн үйлдвэрлэлээ нэмэгдүүлэх зорилгоор газар тариалан, хүнсний ногоо, жимс жимсгэнэ тариалах иргэдийг бодлогоор дэмжинэ.

3.5.7 Газар тариалангийн тоног төхөөрөмжийн тоог нэмэгдүүлнэ.

# Дөрөв. ХУУЛЬТАЙ МОНГОЛ

## 4. ИРГЭНДЭЭ ҮЙЛЧИЛДЭГ ЗАСАГЛАЛ

4.1 Нас, хүйс, хөгжлийн бэрхшээл гэх мэт аливаа төрлийн ялгаварлан гадуурхалт, хүчирхийллийг ажлын байр, олон нийтийн бүх орчинд таслан зогсооход чиглэсэн үе шаттай арга хэмжээг тогтмол хэрэгжүүлнэ.

4.2 Хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх төвийг сум орон нутгийн нөөц боломжид түшиглэн байгуулж, гэр бүл, сургуулийн орчинд хүүхдийн эрхийг хангах, ажлын байран дахь бэлгийн дарамттай тэмцэх ажлыг эрчимжүүлнэ.

4.3 Хүндэтгэн үзэх шалтгааны улмаас өөрийн биеэр ирж уулзах боломжгүй иргэд төрийн захиргааны албан тушаалтан, албан хаагчидтай онлайнаар уулзах боломжийг бүрдүүлнэ.

4.4 Төрийн байгууллагаас гаргах шийдвэрт ард иргэд, төрийн бус байгууллагын оролцоог нэмэгдүүлж, төрийн үйлчилгээний шийдвэрийг ил тод болгож ажиллана.

4.5 Хууль сурталчлах, таниулах ажлын чанарыг дээшлүүлж, олон нийтэд хууль зүйн мэдээллийг шуурхай, үр дүнтэй хүргэж ажиллана.

4.6 Төсвийн зарцуулалт, төрийн өмчит аж ахуйн нэгжүүдэд тавих иргэний болон хөндлөнгийн хяналтыг нэмэгдүүлнэ.

4.7 Иргэд, аж ахуйн нэгжийн төрөөс авах үйлчилгээг бүрэн цахим хэлбэрт шилжүүлнэ.

4.8 Төрөөс зохион байгуулах аливаа тендер, тендерийн сонгон шалгаруулалтыг аливаа ашиг сонирхлын зөрчлөөс ангид, олон нийтэд ил тод нээлттэй болгоно.

**Тав. АЮУЛГҮЙ, ЭКО БАЯНГОЛ**

## 5. ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН, НОГООН ХӨГЖИЛ

5.1 Хөв цөөрөм байгуулах боломж, нөхцөлийг судлана.

5.2 Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, ангилах, дахин ашиглах, сэргээн ашиглах, дахин боловсруулах үйл ажиллагааг хувийн хэвшлийн байгууллагаар гүйцэтгүүлэх, хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулах зэргээр цогц үйл ажиллагааг шат дараалан авч хэрэгжүүлж "Эко сум" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

5.3 Хог хаягдлын менежментийг сайжруулж, хоёрдогч түүхий эдийг ашиглах нөхцөл боломжийг бүрдүүлнэ.

5.4 Сумын төвд ногоон байгууламж, олон нийтийн хүрээлэнгүүдийн тоог нэмэгдүүлнэ.

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН БАЯНГОЛ СУМЫН АРДЧИЛСАН НАМ**

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
Нутгийн удирдлагын ордон, П.Гэндэнгийн гудамж,
5 дугаар баг, Арвайхээр сум, Өвөрхангай аймаг, 62173,
Утас/Факс: (976) 7032 3253,
Цахим шуудан: uvurkhangai@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.04.17 № 319

танай __________-ны №__________-т

БОГД СУМЫН АРДЧИЛСАН
НАМЫН ХОРООНД

Дүгнэлт хүргүүлэх тухай

Төрийн Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх заалт, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5 дахь хэсгийг үндэслэн Богд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгуульд оролцох Богд сумын Ардчилсан намын хорооны Сонгуулийн мөрийн хөтөлбөр, хандивын тайланд хийсэн аудитын дүгнэлтийг хүргүүлж байна.

Хавсралт 20 хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР О.БАТЖАРГАЛ

6225020514

D:\Auditiin gazar\baiguullagiin dotood barimt\A4

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, П.Гэндэнгийн гудамж,
5 дугаар баг, Арвайхээр сум, Өвөрхангай аймаг, 62173,
Утас/Факс: (976) 7032 3253,
Цахим шуудан: uvurkhangai@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.04.17 № 208

танай ____________-ны №____________-т

АРДЧИЛСАН НАМЫН БОГД СУМЫН ХОРООНД

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд заасан шаардлагад нийцсэн талаарх дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3, 5.4-т заасны дагуу Төрийн аудитын байгууллага Богд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгуульд оролцох Ардчилсан намын Богд сумын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Богд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгуульд оролцох Ардчилсан намын Богд сумын хороо нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгаа гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь Богд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгуульд оролцох Ардчилсан намын Богд сумын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн

бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

**Дүгнэлт**

Ардчилсан намын Богд сумын хорооны Богд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Ардчилсан намын Богд сумын хорооны мөрийн хөтөлбөр (14 хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Богд сумын Сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР О.БАТЖАРГАЛ

**"БАЯЛАГТАА ЭЗЭН БОГД"**

**СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ, ДҮҮРГИЙН ИТХ-ЫН СОНГУУЛИЙН 2024 ОНЫ СОНГУУЛЬД ОРОЛЦОХ ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН **БОГД** СУМЫН АРДЧИЛСАН НАМЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

Монгол Улсын тусгаар тогтнол, Үндэсний эрх ашиг, Үндсэн хуульт Ардчиллаа хамгаалан бэхжүүлж, хувь хүний эрх, эрх чөлөө, шударга ёс хуулийн засаглал, чөлөөт зах зээл, иргэний нийгмийн зарчимд суурилсан тогтвортой хөгжлийн төлөө Монгол улсын урт хугацааны хөгжлийн баримт АЛСЫН ХАРАА 2050 хөтөлбөрт Монгол хүн бүр хүсэл мөрөөдөлтэй, өрх бүр аз жаргалтай амьдрах хөгжлийн боломжийг дэмжсэн, иргэд нь эрх чөлөөтэй, эрх тэгш, хариуцлагатай, Ардчилсан Монгол Улсаа хөгжүүлэхийг ЭРХЭМ ЗОРИЛГО болгож.

1. Монгол хүний эрх, эрх чөлөө, бие даасан байдлыг хангах
2. Хувийн өмч, өрсөлдөөнт зах зээл, төрийн хязгаарлагдмал оролцоо, хуулийн засаглалыг хөгжүүлэх
3. Үндэсний өв уламжлал, түүх соёлоо дээдлэн үнэт зүйлээ болгон тунхагласан

6217143881
ИЮА0059 9044094

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН БОГД СУМЫН АРДЧИЛСАН НАМ 2024-2028 оны аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуульд оролцох "**БАЯЛАГТАА ЭЗЭН БОГД**" мөрийн хөтөлбөрөө Та бүхэндээ толилуулж байна.

УРИА: ХҮН БҮРД ОРЛОГО – ӨРХ БҮРД ӨСӨЛТ

НЭР:БАЯЛАГТАА ЭЗЭН БОГД

ГАРЧИГ

Нэг. ХУВЬ ХҮНИЙ ХӨГЖИЛ, ЭРХ ЧӨЛӨӨ

1.1. ӨРСӨЛДӨХ ЧАДВАРТАЙ БОЛОВСРОЛ

1.2. ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

1.3. ХҮН АМЫН ХӨГЖИЛ, ХҮН, ӨРХ ГЭР БҮЛ

1.4. АЖЛЫН БАЙР ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

1.5. НИЙГМИЙН ХАМГААЛАЛ

1.6. СОЁЛ, УРЛАГ, СПОРТ

Хоёр. ХҮРТЭЭМЖТЭЙ ЭДИЙН ЗАСАГ

2.1 .ӨСӨЛТИЙН БОДЛОГО ЖИЖИГ ДУНД БИЗНЕС

2.2. ДЭД БҮТЭЦ

2.3. АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ

2.4. ХҮНСНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ

Гурав. ЭЗЭН МОНГОЛ

3.1. ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛ

3.3. БЭЛЧЭЭР АШИГЛАЛТ

3.4. МАЛ АЖ АХУЙ

3.5. ГАЗАР ТАРИАЛАН

Дөрөв. ХУУЛЬТАЙ МОНГОЛ

4.1. ИРГЭНДЭЭ ҮЙЛЧИЛДЭГ ЗАСАГЛАЛ

Тав. АЮУЛГҮЙ, АМГАЛАН МОНГОЛ

5.1. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ

## Нэг. ХУВЬ ХҮНИЙ ХӨГЖИЛ, ЭРХ ЧӨЛӨӨ

### 1.1. ӨРСӨЛДӨХ ЧАДВАРТАЙ БОЛОВСРОЛ

Хүн амын тогтвортой өсөлтийг хангаж, хүн бүрийг эрдэм боловсрол төгс, хөдөлмөрч, бүтээлч сэтгэлгээтэй, эрүүл амьдралын хэв маягийг хэвшил болгосон, Баян-Өндөр нутгийнхаа байгаль, түүх соёл, уламжлалаараа бахархсан өв тэгш хүмүүжлээр төлөвшүүлэн, хангалуун сайхан амьдрах эрхийг дээдэлсэн хувь хүний хөгжлийн бодлого хэрэгжүүлнэ. Нийгмийн халамжийн үйлчилгээг зөвхөн зорилтот бүлэгт чиглүүлнэ.

1. ЕБС-ийн аймаг Улсын олимпиад, ЭЕШ-нд амжилт үзүүлсэн багш сурагчдыг мөнгөн урамшуулал олгох, бодлогоор дэмжих
2. Хүүхэд бүрийг хөгжүүлж, бүтээлч сэтгэлгээтэй, өөртөө итгэлтэй, эх нутгийнхаа байгаль, түүх, үндэсний хэл соёл, уламжлалаар бахархдаг хүмүүжил олгоно.
3. Хүүхэд гэр бүл, цэцэрлэг, сургуулийн орчинд эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх, орчны эрүүл мэндийг сайжруулах бодлогыг нийгмийн эрүүл мэндийн үндсэн чиглэл болгоно.
4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг соёлын үйл ажиллагаанд идэвхтэй оролцуулах, тэдний авъяас, хөдөлмөр бүтээлийг дэмжиж ажиллана.
5. Багш нарын мэдлэг, ур чадварыг тухай бүрд нь дээшлүүлж, давтан сургахад орон нутгийн төсвийн санхүүжилтээс дэмжлэг үзүүлэх ажлыг эхлүүлнэ.

### 1.2. ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

1. ЭМТ-ийн чанар хүртээмжийг сайжруулж эмч ажилчдын орон тоог нэмэгдүүлнэ.
2. Эх хүүхэд,өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.
3. Иргэдийн халдварт болон халдварт бус өвчлөл, эх болон нярайн эндэгдлийг бууруулж, урьдчлан сэргийлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулна.
4. Богд сумын эрүүл мэндийн төвийг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангана.
5. Хүнийг өвдөхөөс нь өмнө урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоог өрх гэрийн түвшинд тогтмол хийдэг эрүүл мэндийн үйлчилгээний шинэ хэлбэрийг бий болгоно.
6. Иргэн бүрийг насны бүлэгт нь тохирсон урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоонд хамруулна.

### 1.3. ХҮН АМЫН ХӨГЖИЛ, ӨРХ ГЭР БҮЛ

1. Хүүхэд, залуучуудын хөгжлийн төв байгуулж хүүхэд, залуучууд цагийг зөв боловсон өнгөрүүлэх орчин нөхцөлийг нэмэгдүүлнэ.
2. Хүүхдийн хүмүүжил, төлөвшлийн асуудалд онцгой анхаарч, цэцэрлэгийн өмнөх насны хүүхдийг хүмүүжүүлэх олон талт ажлыг зохион байгуулна.
3. Гэр бүлийн гишүүн бүрд гэр бүлийн боловсрол олгох, ажил хөдөлмөр эрхлэх, санхүү, бизнесээ хөгжүүлэх, амьдрах орчноо хамтдаа сайжруулах, мэдлэг ур чадварын сургалт, зөвлөмжөөр хангагдах боломжийг орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан хэрэгжүүлнэ.
4. Хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэж, дарамт, мөлжлөгийн бүх хэлбэрээс хамгаалах хуулийн хэрэгжилтийг сайжруулна.
5. Хүүхдийг цахим мэдээллийн халдлагаас хамгаалах, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлнэ.

6. Иргэд чөлөөт цагаа өнгөрүүлэх зориулсан цахим төв байгуулна.

## 1.4. АЖЛЫН БАЙР ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежментийг сайжруулахад чиглэсэн бодлого хэрэгжүүлнэ.
2. Хөдөлмөрийн зах зээл дээр эрэлтийн судалгааны чанарыг сайжруулж, хэрэгцээтэй байгаа ажил, мэргэжлийг эдийн засгийн салбар, ажил мэргэжлээр нарийвчлан гаргаж, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын алсэлттэй нягт уялдуулна.

## 1.5. НИЙГМИЙН ХАМГААЛАЛ

1. Ахмадын өдөр өнжүүлэх төвийг өргөжүүлж, байнгын ажиллагаатай болгоно. .
2. Малчдын нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлж, тэдний нийгмийн баталгааг хангана.
3. Албан хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулна.
4. Шинээр ирсэн болон орон байр шаардлагатай төрийн албан хаагчдад ашиглалтгүй байгаа байрнуудыг засварлаж орон байраар хангана.
5. Сумын төвийн худгуудад ус цэвэршүүлэгч төхөөрөмж байршуулан картжуулна.

## 1.6. СОЁЛ, УРЛАГ, СПОРТ

1. Улс аймагт спортын амжилт үзүүлсэн тамирчдыг урамшуулах бодлогоор дэмжих
2. Уламжлалт өв соёлоо бодлогоор дэмжин монгол хүнийг төлөвшүүлэхэд онцгойлон анхаарна.
3. Хөлбөмбөг сагсан сагсан бөмбөг элсний волейболын талбай бүхий спортын гадаах цогцолбор байгуулна.
4. Түүх соёлын дурсгалт газрын хамгаалалтыг сайжруулж, соёлын өвийг хамгаалагч, харгалзагч нарын урамшууллыг нэмэгдүүлнэ.
5. Спортын улс, бүсийн хэмжээний уралдаан, тэмцээнийг зохион байгуулахад дэмжлэг үзүүлнэ, улс бүс, олон улсын тэмцээнд оролцох баг тамирчдын зардалд орон нутгийн эгэээс дэмжлэг үзүүлдэг тогтолцоог бий болгоно.

# Хоёр. ХҮРТЭЭМЖТЭЙ ЭДИЙН ЗАСАГ

## 2.1. ӨСӨЛТИЙН БОДЛОГО ЖИЖИГ ДУНД БИЗНЕС

1. Хоршоог дэмжих сангийн зээлийг үйл ажиллагаа явуулж байгаа хоршоодод тэгш хүртээмжтэй, ялгаварлалгүйгээр олгоно.
2. Нутгийн Брэнд бүтээгдэхүүн бий болгоход бодлогоор дэмжинэ.
3. Ажиллах хүчийг нэмэгдүүлэх, ядуурлыг бууруулах, ажлын байр олноор бий болгохыг нэн тэргүүний зорилт гэж үзэн шинэ ажлын байрыг бий болгох бүтээн байгуулалт, бизнесийн төслүүдийг бүх талаар дэмжиж хөгжүүлнэ.
4. Малын гаралтай түүхий эдийг боловсруулах, бүтээгдэхүүн үйлдвэрлэх хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлэн ажлын байрыг бий болгохыг дэмжинэ.
5. Орон нутгийн аж ахуй нэгж, компаниудын чадавх, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх төслүүдийг дэмжинэ.

6. Мал аж ахуй, газар тариалан, гахай, тахиа, зөгийн аж ахуйд суурилсан орон нутгийн онцлог шинэ брэнд бүтээгдэхүүний бизнес загвар хөгжүүлэхийг дэмжинэ.

## 2.2. ДЭД БҮТЭЦ

1. Дулаан, цэвэр бохир, инженерийн шугам сүлжээг шинэчлэнэ.
2. Орон сууцжуулах ажлыг эхлүүлнэ.
3. Стандартад нийцсэн камерын системтэй болгоно.
4. Сумын төвийн хороолол гудамжийг цэгцэлж, жишиг гудамжууд бий болгоно.
5. Сумын төвийн гэрэлтүүлэгийг сайжруулж, шинэчлэл хийнэ.
6. Сумын төвд хатуу хучилттай зам тавих ажлыг холбогдох байгууллагад уламжилж шийдвэрлүүлнэ.
7. Ховд голын гүүр шинээр барих
8. Сумын төвийн ногоон байгууламжийг нэмэгдүүлнэ.

## 2.3. АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ

1. Монгол ахуй сурталчлах орон нутгийн онцлогт нийцсэн аялал жуулчлалын хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.

## 2.4. ХҮНСНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ

1. Хүн амын гол нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүний дотоод хэрэгцээг чанартай хүнсээр хүртээмжтэй хангаж, дотоод зах зээл дэх хүнсний нийлүүлэлтийн сүлжээнд аюулгүй байдлын тогтолцоог нэвтрүүлнэ.
2. Жимс, жимсгэний үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, хэрэгцээг дотооддоо хангахад чиглэгдсэн хувийн хэвшлийн санаачилгыг дэмжин хэрэгжүүлнэ.
3. Орон нутгийн иргэд хүнсний хэрэгцээгээ өөрөө хангах, хүлэмжийн аж ахуй эрхлэх санаачилгыг бүх талаар дэмжиж хүнсний ногооны хэрэгцээг сумандаа тариалах боломжийг бүрдүүлнэ.
4. Дөрвөн улирлын хүлэмжийн төсөл хөтөлбөрийг хувийн хэвшилтэй хамтран хэрэгжүүлнэ.
5. Мах хадгалах, хөлдөөх хөргүүрийн тоог нэмэгдүүлнэ.
6. Төмс, хүнсний ногооны төрөлжсөн зоорь барих ажлыг үргэлжилүүлнэ.

**Гурав. ЭЗЭН МОНГОЛ**

## 3.1. ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛ, ШИНЭ ХӨДӨӨ" ХӨТӨЛБӨР

1. Бэлчээрийн менежментийг сайжруулна.
2. Бэлчээрийн болон хүн амын усан хангамжийг сайжруулна
3. Жижиг дунд үйлдвэрлэлийг бүх талаар дэмжинэ.
4. Хүнсний дэлгүүрүүдийг дулаанд холбох ажлыг эхлүүлнэ.
5. Иргэдийн санаачилгад суурилсан "шинэ хоршоо" хөтөлбөрийг хэрэгжүүлж малчдын өрхийн орлоыг нэмэгдүүлэх ажлыг бодлогоор дэмжинэ.
6. Мал аж ахуйн салбарыг эдийн засгийн үр ашигтай, орчин үеийн шинэ технологи, инновацад суурилж, хөгжүүлэн мэдлэг бүхий малчдыг малчин бизнесмэн болгох

замаар тогтвортой орлого бүхий хүчтэй дундаж давхаргыг тэлэх бодлого хэрэгжүүлнэ.

1. Мах хадгалах, хөлдөөх хэргүүрийн тоо нэмэгдүүлэх
2. Малчдын орлогыг нэмэгдүүлэх зорилгоор сүү цагаан идээ үйлдвэрлэж буй иргэдийг олон нийтэд сурталчилан таниулж, үзэсгэлэн худалдаанд тогтмол хамруулна.

## 3.3. БЭЛЧЭЭР АШИГЛАЛТ

1. Малчдын хамтын оролцоонд тулгуурлан бэлчээр нутгийн тогтвортой ашиглалтыг хангаж, доройтсон бэлчээрийг сэргээх арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлнэ.
2. Бэлчээр хамгаалах зорилгоор мэрэгч болон байгаль орчинд сөрөг нөлөө ихтэй хортон шавьж устгах ажлыг зохион байгуулж хийнэ.
3. Оторт явсан малчдын асуудлыг сум хоорондын түвшинд шийдэж, өвөлжилт, хаваржилтын асуудлаар цогц арга хэмжээ авна.
4. Бэлчээрийн нөөцийг нэмэгдүүлж ногоон тэжээл тариалах нөхцөлийг нэмэгдүүлнэ.
5. Бэлчээрийн олон наст ургамал тариалах иргэдийг дэмжиж ажиллана.
6. Бэлчээрийн даацыг харгалзан, гүний болон гар худгуудыг шинээр гаргана.
7. Булаг шандны эхийг хашиж хамгаална.
8. Сум дотроо ашиглах нөөц бэлчээрийг сумын тусгай хамгаалалтад авч зүй зохистой ашиглах арга хэмжээг зохион байгуулна.

## 3.4. МАЛ АЖ АХУЙ

1. Эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх, малын чанар сайжруулах, мал бордох аргачлалыг нэвтрүүлэх
2. Залуу малчдыг дэмжих бодлого хэрэгжүүлж, бодлого үйл ажиллагаар дэмжиж тусгайлсан хөтөлбөр хэрэгжүүлнэ.
3. Малжуулах гэржүүлэх төслийг хэрэгжүүлнэ.
4. Малыг чанар, үүлдэр, угсааг сайжруулж эдийн засгийн ашигтай технологид суурилсан мал аж ахуйг бодлогоор дэмжинэ.
5. Махыг зах зээлд борлуулах хяналтын горимыг сайжруулж, малыг вакцин, туулгад бүрэн хамруулан эрүүлжүүлэх ухаалаг хяналтын системийг хөгжүүлнэ.
6. Хөдөөгийн малчин өрхийг дэмжин "Малжуулах хөтөлбөр"-ийг хэрэгжүүлнэ.
7. Малын арьс шир боловсруулах цех байгуулж малын гаралтай түүхий эдийг нэмүү өртөг шингэх боломжийг нэмэгдүүлнэ.

6217143681
ИОА0059 9044094

## 3.5. ГАЗАР ТАРИАЛАН

1. Малын тэжээл үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, бодлогоор дэмжинэ.
2. Сумын төвд хүлэмжийн цогцолбор байгуулна.
3. Мод тарих ажлыг үргэлжлүүлж авто зам дагуу Сумын төвийн хойд талаар ойн зурвас байгуулна.

# Дөрөв. ХУУЛЬТАЙ МОНГОЛ

## 4.1. ИРГЭНДЭЭ ҮЙЛЧИЛДЭГ ЗАСАГЛАЛ

1. Нас, хүйс, хөгжлийн ялгаа, гэх мэт аливаа төрлийн ялгаварлал, дарамт, хүчирхийллийг ажлын байр, олон нийтийн бүх орчинд таслан зогсооход чиглэсэн үе шаттай арга хэмжээг тогтмол хэрэгжүүлнэ.
2. Хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх төвийг сум орон нутгийн нөөц бололцоонд тулгуурлан байгуулж, гэр бүл, сургуулийн орчинд хүүхдийн эрхийг хангах, ажлын байран дахь бэлгийн дарамттай тэмцэх ажлыг эрчимжүүлнэ.
3. Хүндэтгэн үзэх шалтгааны улмаас өөрийн биеэр ирж уулзах боломжгүй иргэд төрийн захиргааны албан тушаалтан, албан хаагчидтай онлайнаар уулзах боломжийг бүрдүүлнэ.
4. Төрийн байгууллагаас гаргах шийдвэрт ард иргэд, төрийн бус байгууллагын оролцоог нэмэгдүүлж, төрийн үйлчилгээний шийдвэрийг шилэн болгож ажиллана.
5. Хууль сурталчлах, таниулах ажлын чанарыг дээшлүүлж, олон нийтэд хууль зүйн мэдээллийг шуурхай, үр дүнтэй хүргэж ажиллана.
6. Төсвийн зарцуулалт, төрийн өмчит аж ахуйн нэгжүүдэд тавих иргэний болон хөндлөнгийн хяналтыг нэмэгдүүлнэ.
7. Иргэд, аж ахуйн нэгжийн төрөөс авах үйлчилгээг бүрэн цахим хэлбэрт шилжүүлнэ.
8. Төрөөс зохион байгуулах аливаа төсөл, тендерийн сонгон шалгаруулалтыг авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид, олон нийтэд ил тод нээлттэй болгоно.

## Тав. АЮУЛГҮЙ, АМГАЛАН МОНГОЛ

### 5.1. ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН, НОГООН ХӨГЖИЛ ЭКОСИСТЕМИЙН ТЭНЦВЭРТЭЙ БАЙДАЛ

1. Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин ашиглах, сэргээн ашиглах, дахин боловсруулах үйл ажиллагааг хувийн хэвшлийн байгууллагаар гүйцэтгүүлэх, хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулах зэргээр цогц үйл ажиллагааг шат дараалан авч хэрэгжүүлнэ.
2. Хог хаягдлын менежментийг сайжруулж хоёрдогч түүхий эдийг ашиглах нөхцөл боломжийг бүрдүүлнэ.
3. Сумын төвд ногоон байгууламж, боловсон жорлонгуудын тоог нэмэгдүүлнэ.

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН БОГД СУМЫН АРДЧИЛСАН НАМ

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН БОГД СУМЫН ХОРОО

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, П.Гэндэнгийн гудамж,
5 дугаар баг, Арвайхээр сум, Өвөрхангай аймаг, 62173,
Утас/Факс: (976) 7032 3253
Цахим шуудан: uvurkhangai@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.04.17 № 329

танай __________-ны №__________-т

ЗҮҮНБАЯН-УЛААН СУМЫН
АРДЧИЛСАН НАМЫН
ХОРООНД

Дүгнэлт хүргүүлэх тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх заалт, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5 дахь хэсгийг үндэслэн Зүүнбаян-Улаан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгуульд оролцох Зүүнбаян-Улаан сумын Ардчилсан намын хорооны Сонгуулийн мөрийн хөтөлбөр, хандивын тайланд хийсэн аудитын дүгнэлтийг хүргүүлж байна.

Хавсралт 14 хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР О.БАТЖАРГАЛ

6225020518

D:\Audit\In gazar\baiguullagiin dotood barimt\A4

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
Нутгийн удирдлагын ордон, П.Гэндэнгийн гудамж,
5 дугаар баг, Арвайхээр сум, Өвөрхангай аймаг, 62173,
Утас/Факс: (976) 7032 3253,
Цахим шуудан: uvurkhangai@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.04.17 № 201

танай ____________-ны №______________-т

АРДЧИЛСАН НАМЫН
ЗҮҮНБАЯН-УЛААН СУМЫН
ХОРООНД

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд заасан шаардлагад нийцсэн талаарх дүгнэлт

